



**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНЫ НУТАГ
ДЭВСГЭРТ БАЙРЛАХ МСМ ГРУПП ХХК-НИЙ
“ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ” ТӨСЛИЙН 2022
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

ХЯНАСАН:

БОАЖЯ-НЫ ХБОБНГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:

“МСМ ГРУПП” ХХК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ЗАХИРАЛ



Э.БОЛОРМАА

“МСМ ГРУПП” ХХК-ИЙН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ
БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ ЗОХИЦУУЛАГЧ

Г.БААСАНДАШ

АГУУЛГА

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	3
2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	16
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	20
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНҮҮД	24
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ	25
5.1 СӨРӨГ НӨЛӨӨЛЛ	26
5.2 АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ.....	26
5.3 УРГАМЛАН НӨМРӨГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ	28
5.4 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЯВЦАД ҮҮСЭЖ БОЛЗОШГҮЙ ОСОЛ, ЭРСДЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ	28
6. НӨХӨН СЭРГЭЭЛТ, ТОХИЖИЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	30
7. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..	32
8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	32
9. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	32
10. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	32
11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	36
12. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	38
13. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ.....	39
13.1 ХӨРСНИЙ ЭВДРЭЛ, ГЭМТЭЛ.....	40
13.2 АГААР	51
13.3 УС	58
14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ.....	62
15. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ..	62
16. ХАВСРАЛТ	63

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1 ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Төсөл хэрэгжүүлэгч:	“МСМ Групп” ХХК
Улсын бүртгэлийн дугаар:	9019009002
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	МСМ Групп ХХК-н байр, Чингисийн өргөн чөлөө- 62, Үйлдвэрийн баруун бүс -17070, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Улаанбаатар – 211213, Монгол улс, Т/шуудан хайрцаг – 154
Утас:	(+976) 70181111
И-мэйл:	information@msmco.net www.msmsgroup.mn

МСМ Групп ХХК нь анх 1998 онд байгуулагдсан бөгөөд компанийн хувьцааг Лауренц Мелшерс, Дэвид Райнер, Монголиа Экуйпмент Сервисес компани нар эзэмшдэг. МСМ Групп ХХК нь дараах 4 салбарт үйл ажиллагаа явуулдаг.


1. Барилга, уул уурхайн тоног төхөөрөмжийн салбар
2. Автомотивын салбар
3. Хөдөө аж ахуйн салбар
4. Шингэн хүнсний салбар

1.2 ТӨСЛИЙН БАЙРШИЛ

Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрладаг бөгөөд урд талаараа төв зам ба Туул гол, хойд талаараа 3-р цахилгаан станцтай хил залган оршдог. “МСМ Групп” ХХК нь 2019 онд өөрийн үйлдвэрийн баруун бүс 17-070-60 тоотод, 2282 м2 талбай бүхий химийн бодис хадгалах зориулалттай 2 агуулахын байрыг тус тус ашиглалтанд оруулан, мэргэжлийн хяналтын, хяналт шалгалтаар дүгнэлт гаргуулан химийн бодис хадгалах зориулалт стандартын дагуу тохижуулан үйл ажиллагаа явуулж байна.

“МСМ Групп” ХХК нь 2019 онд БНХАУ, ОХУ, Тайвань, Малайз, Индонез, Австрали, Сингапур улсад үйлдвэрлэсэн 15 төрлийн химийн нэгдэл агуулсан 971 кг химийн нэгдэл агуулсан бүтээгдэхүүнийг импортлон худалдаалахаар захиалга авч “Грийн Ассесмент” ХХК нь Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголыг гүйцэтгэн 2019 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн Байгаль орчны үнэлгээний мэргэжлийн дэд зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн тус тус баталгаажуулсан байна.

Химийн бодисын агуулахын байр нь химийн бодис хадгалахад тавигдах шаардлагын дагуу тусгай агуулахын өрөө гарган бэлтгэсэн бөгөөд агуулах нь 1 давхар, зоорьгүй, газардуулга, аянга зайлуулагчтай, бетон шалтай байгалийн болон зохиомол гэрэлтүүлэг хүрэлцээтэй, агаар сэлгэх механик салхивчтай, цонх нь төмөр тортой, дулаан, бохир ус нь төвийн системд холбогдсон, гадна талын хашаа нь блокон ханатай, 24 цагийн харуул хамгаалалттай, хүн ам бага суурьшсан хороолол, усан сан бүхий газар, үер, усны аманд байрлаагүй хийгдсэн болно.



Зураг 1. Химийн бодисын агуулахын байршил.

1.3 ХИМИЙН БОДИСЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

“МСМ Групп” ХХК нь БНХАУ, ОХУ, Тайвань, Малайз, Индонез, Австрали, Сингапур улсад үйлдвэрлэсэн 173 төрлийн химийн нэгдлийг Замын үүд, Алтанбулаг, Буянт ухаа, Гашуун сухайтын боомтоор импортлон химийн бодисын агуулахад ангилан хадгалж, гэрээний дагуу худалдаалдаг.

1.4 ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ

Химийн бодисын агуулах нь нийт 2112 м2 талбайтай, 8.0 мян.тн бодис нэг дор хадгалах багтаамжтай ба хадгалж буй химийн бодисыг худалдаалж сэлгэх хүчин чадлаар тооцвол жилд 90 мян.тн бодис хадгалах хүчин чадалтай.

1.5 ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ

“МСМ групп” ХХК нь уул уурхайн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, усны шугам хоолойд өнгөр үүсэхээс сэргийлдэг, хатуу шингэнийг ялгах зэрэг үйл ажиллагаанд хэрэглэдэг, нийт 179 нэр төрлийн химийн хортой болон аюултай бодисыг тус 2 агуулхад (Зураг №2) хадгалан худалдаалдаг. Эдгээр химийн нэгдэл агуулсан бүтээгдэхүүнүүдийн мэдээллийг тайланд хавсралтаар оруулсан.

Хүснэгт №1 Агуулахад хадгалагдаж буй бодисын жагсаалт

№	Монгол нэр	Томъёо	CAS дугаар	Жилд оруулж ирэх хэмжээ тн
1	Хөрс нягтруулж бэхжүүлэх шахуурга резин	Sodium silicate solution, modified; methylenediphen diisocyanate; diiphenylmethane-4,4'-diisovanate	-	800
2	Бетоны ус тусгаарлах цементэн нэмэлт	Preparation based on: modified cement mortar	65997-15-1, 497-19-8, 133-37-9	500
3	Бэхжиж хатсан бетоны үлдэц арилгагч	Carboxylic acid amide; derivative	-	250
4	Тоосжилт дарах бодис	Poly(oxy-1,2-ethanediyl), .alpha.-tridecyl-.omega.-hydroxy-, branched; 1,2-benzisothiazol-3(2H)-one; 1,2-benzisothiazolin-3-one; 2-Methyl-2H-isothiazol-3-one	2634-33-5	2100
5	Агшдаггүй цементэн зуурмаг	Modified cement mortar	1305-78-8, 65997-15-1	250
6	Флотацийн урвалж	Polypropylenglycol 1-Hexanol, 2-Ethyl, manufactured of by products from distillation residues	25322-69-4, 68609-68-7, 104-76-7, 68609-68-7, 94277-83-5	3200
7	Уусгагч бодис	1-Propene hydroformylation, products, distillation residues	97281-08-8, 71-36-3, 78-83-1, 123-72-8, 68526-89-6	700
8	Бактер устгагч	p-chloro-m-cresol-Ethylene glycol	59-50-7, 107-21-1	60
9	рН тэнцвэржүүлэгч	Caustic soda; Lye; Sodium hydroxide; solid; Sodium hydrate	1310-73-2	15
10	Бетоны нэмэлт	2-methylpentane-2, 4- diol	107-41-5	450
11	Метал уусгагч бодис	Polyether Polyol	50586-59-9	60
12	Бактер устгагч	Formalin	30525-89-4	24

13	Ус тусгаарлагч	polyetherpolyol, 4,4'-methylenedihenyl diisocyanate; diphenylmethane-4,4; di-isoc ante	68479-98-1, 26447-40-5	600
14	Калийн хлорид	C1-KIC1K	7447-40-7	200
15	Бетоны уян налархайжуулагч поликарбоксилат эфир	Aqueous solution based on: polycarboxylate ether, inorganic salts	97105-14-1	900
16	Анкер боолтны чигжээс резин	Diphenylmethane-4, 4'-diisocyanate (MDI), Glycerol in water	2855-13-2; 1704-62-7; 56-81-5; 9016-87-9; 112-15-2	600
17	Дулаалгын шүршдэг хөөс	Polyol, Isocyanate	1717-00-6, 9016-87-9, 101-68-8, 1305-62-0, 107-21-1, 64741-65-7, 9016-87-9, 38640-62-9	600
18	Бетон хүчитгэлийн праймер цавуу	Epoxy resin, Polymeric amine, aliphatic	25068-38-6, 2855-13-2, 9046-10-0, 100-51-6, 25513-64-8, 90-72-2, 25085-99-8	90
19	Ус чийгнээс хамгаалах түрхлэг	Isocyanate, Calcium salts in water, polyetherpolyol	1717-00-6, 9016-87-9, 101-68-8, 1305-62-0, 107-21-1, 64741-65-7, 9016-87-9, 38640-62-9, 9009-54-5	350
20	Цементэн заслын зуурмаг	Quartz(SiO ₂), 14808-60-07 ,65-997-Portland cement/ 15-1 ASTM, C-15(I/ TYPE I)	14808-60-07; 65-997-15-1	600
21	Цементэн гроутоны нэмэлт	Magnesium Oxide, Cement portland Chemicals, Calcium Oxide	1309-48-4, 65997-15-1, 1305-78-8	400
22	Баяжмал хөөсрүүлэгч	-	-	1800
23	Бетон зуурмагийг уян налархайжуулагч нэмэлт бэлдмэл	STRCH ₂ -o-CH ₂ ET, AES1730-40(STRC=OES)	-	900
24	Бетон зуурмагийн бэхжилтийг түргэсгэгч нэмэлт бэлдмэл	-	-	1600
25	Бетон зуурмагийн шинж чанарыг сайжруулах, уян налархайжуулагч нэмэлт	Silica	69012-64-2	9100

26	Поликарбоксилатын эфир	STRCH2-O-CHZET,AES1730{0(STRC=оES)	-	1100
27	Мастерфиниш Ар Эл 211 бетоны шахуурга зөөллөгч	-	8002-13-9	50
28	Кюр эн харден /Мастеркюр 260/ бетон хатаагч	-	1344-09-8	140
29	Зай хураагуурын бүрдэл	-	7439-93-2, 7719-09-7, 7782-42-5, 133-86-4, 7446-70-0, 7447-41-8, 2207803-51-8, 21324-40-3, 96-49-1, 616-38-6, 105-58-8, 24937-79-9, 7440-50-8, 7429-90-5	1
30	МастерРок Эйч Си Эй, бетоны гидратацын урвал зохицуулагч	2-Phosphonobutane-1,2,4-tricarboxylic acid; Citric acid	6419-19-8, 77-92-9, 7732-18-5	630
31	Нэрмэл Керосин	-	-	700
32	Юкрит шингэн пигмент - олон өнгөтэй, өнгө оруулагч	-	-	9
33	Юкрит Пи Ти 1 Эм Эф, шалны полиуретан бодис	isocyanate; Diphenylmethane-4,4'-diisocyanate; diphenylmethane-2,4'-diisocyanate;Benzene, 1,1'-methylenebis[2-isocyanato	-	270
34	Юкрит Пи Ти 1 Ю Ди, шалны полиуратен бодис	Calcium dihydroxide; Cement, portland	-	250
35	Юкрит бүрэлдэхүүн 3 Ю Ди 200, шалны полиуретан бодис	Portland cement	-	45
36	Мастертоп 330, засварын цементэн хольц	-	65997-15-1, 7632-00-0	90
37	МастерСиль Ти Си 258, засварын хольц	Cyclohexane, 5-isocyanato-1 (isocyanatomethyl)1,3,3-trimethylhomopolymer; Cyclohexane, 5-isocyanato-1-(isocyanatomethyl)1,3,3-trimethylhomopolymer	64742-95-6, 53880-05-0, 4098-71-9, 77-58-7, 4299-07-4	16
38	Мастерэмако Пи 157, засварын цементэн хольц	-	25103-58-6	160

39	Локсэт резин капсул, өрөмдлөгийн бэхэлгээний жийрэг	-	100-42-5	300
40	Анионик флокулянт (Хатуу шингэнийг ялгагч бодис)	polyacrylamide, anionic	-	3550
41	Тоос бууруулагч	-	8002-13-9	420
42	Неопор Кей эн 2200, Хөөсөнцөр хавтангийн түүхий эд	polystyrene, graphite	109-66-0, 78-78-4, 9003-53-6, 9003-53-6, 109-66-0, 78-78-4	150
43	Айсоцианэйтэ, Сэндвич хавтангийн хөөс	-	9016-87-9	150
44	Гуарфлок Өтгөрүүлэгч	-	-	5
45	Аж үйлдвэрийн усан хөргөлтийн системийн зэв арилгагч	-	-	2700
46	Аж үйлдвэрийн усан хөргөлтийн системийн зэв арилгагч	-	143-239-08-1	320
47	Аж үйлдвэрийн усан хөргөлтийн системийн зэв арилгагч	-	37971-36-1, 7732-18-5	320
48	Аж үйлдвэрийн хөргөлтийн системийн микробиологийн тэнцвэржүүлэгч	-	7758-19-2	360
49	Давсны хүчил	HCL	7647-01-0	360
50	Бетон зуурмагийг хатсаны дараа хагараах сэргийлэх нэмэлт бэлдмэл	Solvent naphtha (petroleum), medium aliph.	64742-89-7, 68131-77-1	360
51	Хүйтэн нөхцөлд бетон зуурмаг цутгахад хэрэглэх нэмэлт бэлдмэл	-	540-72-7, 13477-34-4	360
52	Бетон зуурмагийг агааржуулагч нэмэлт	synthetic polymerizates; Sodium dodecylbenzenesulfonate; Resin acids and Rosin acids, potassium salts; Sodium dodecylbenzenesulfonate	61790-50-9	320

53	Бетон зуурмагийн бэхжилтийг түргэсгэгч, уян налархайжуулагч нэмэлт бэлдмэл	STRCH2-O-CHZET,AES1730{0(STRC=оES)	27167-87-0, 50-00-0, 67-56-1	90
54	Бетон зуурмагийн насосны хоолой тослох	norganic salts; Sodium dodecyl sulphate	151-21-3	300
55	Бетон зуурмагийн бэхжилтийг түргэсгэгч уян налархайжуулагч нэмэлт бэлдмэл	biphenyl-2-ol; 2-hydroxybiphenyl; 2-phenylphenol (ISO)	1310-73-2, 90-43-7	300
56	Зэс уусган баяжуулагч	Distillates (petroleum), hydrotreated light; Kerosine; 5-Nonylsalicylaldehyde oxime; 1-(2-Hydroxy-5-tert-nonylphenyl)ethan-1-one oxime; 4-nonylphenol, branched	84852-15-3	600
57	Усны зэврэлтийг удаашруулагч	Sodium Tolyltriazole	64665-57-2, 1301-73-2	150
58	Усны зэврэлтийг удаашруулагч, Усан хөргөлтийн систем дэхь нян бичил биетийн хэмжээг тогтворжуулагч	Zinc Chloride Phosphoric acid	7646-85-7, 7664-38-2	2700
59	Кабель боолт бэхлэх цементэн зуурмаг	Modified cement; mortar	65997-15-1, 1305-78-8, 1309-48-4, 12042-68-1	9000
60	Шүршмэл бетоны цементэн зуурмаг	Modified cement mortar	65997-15-1	9000
61	Татуурга боолт бэхлэх шахуурга резин	Preparation based on:silicates, glycols in water 4,4'-methylenediphenyl diisocyanate;diphenylmethane-4,4'-diisocyanate	1344-09-8, 1704-62-7, 2855-13-2, 9016-87-9, 112-15-2	3000
62	Антискалант (Усны шугамд өнгөр үүсэхээс сэргийлэх бодис)	Acrylic polymer	6419-19-8, 7732-18-5, 20592-85-2	2800
63	Цементийн чигжээсийн нэмэлт		10043-52-4/68131-74-8	10
64	Хатуулгыг сайжруулах өтгөрүүлэгч		7732-18-5	10
65	Өрөмдлөг хийгдсэн хэсгийг сэргээх синтетик бодис		NA	10
66	Усны урсацыг бууруулагч		NA	10
67	Өрмийн шингэн найруулагч бодис		1302-78-9	5
68	Хөөсрүүлэгч бодис		9082-00-2	10

69	Хөөсрүүлэгч бодис		9016-87-9	10
70	Өрмийн шингэний шингэх бүсийг нягтруулж, битүүлэх бодис		25608-12-2	45
71	Иж бүрэн өрмийн шингэн найруулагч		9004-57-3	135
72	Шингэний тогтоц сайжруулагч	barium sulfate, silica crystalline - quartz,	7727-43-7/14808-60-7	10
73	Кальцийн хлорид	CaCl ₂	10043-52-4	10
74	Өрөмдлөгийн гарцыг нэмэгдүүлэх зориулалт бүхий нунтаг		NA	200
75	Өтгөрүүлэгч нэмэлт бодис		9004-32-4	20
76	Усан суурьтай өрөмдлөгийн сарниулагч бодис		9004-32-4	150
77	Шүүгдсийн бууруулагч бодис		9004-32-4	25
78	Ургамлын гаралтай уусдаг тос		NA	5
79	Цементийн үрэлтийг бууруулах шингэн		68153-01-5	20
80	Цемент	calcium sulfate, Calcium(II) sulfate dihydrate	10034-76-1	75
81	Тос	mineral oil	NA	75
82	Өтгөрүүлэгч		NA	100
83	Шингэрүүлэгч		NA	30
84	Ургамлын гаралтай уусдаг тос		NA	10
85	Яндангийн тос		NA	100
86	Чичирхийлэл, үрэлтийг бууруулах өтгөрүүлсэн тос	naphthenic distillate, heavy, hydrotreated	64742-72-5/68201-19-4	100
87	Тос		NA	50
88	Угаагч бодис		NA	0
89	Гадаргууг задлах хольц		111-76-2	105

90	Усыг зөөлрүүлэх задлах бодис	Ethylenediaminetetraacetic acid, tetrasodium salt, dihydrate	64-02-8/497-19-8	15
91	Усны худаг цэвэрлэгч		7758-16-9	15
92	Техникийн сод	Sodium carbonate	497-19-8	125
93	Бетоны уян налархайжуулагч поликарбоксилат эфир	S'IRCH2-O-CH2ET,AES1730-4tl(STRC=OES)	-	1500
94	Бетоны уян налархайжуулагч поликарбоксилат эфир	S'IRCH2-O-CA2ET,AES1730-40(STRC=OES)	-	750
95	Бетоны уян налархайжуулагч поликарбоксилат эфир	STRCH2-O-CH 2 ET,A;S1730-40(STRC=OES)	-	900
96	Бетоны барьцалдах хугацааг хурдасгагч хөнгөн цагааны сульфат	Al2(SO4)3	10043-01-3	8500
97	Бетоны уян налархайжуулагч поликарбоксилат эфир	S'IRCH2-O-CH2ET,AES1730-40(STRC=OES)	-	900
98	Бетоны уян налархайжуулагч поликарбоксилат эфир	-	-	150
99	Цементийн нэмэлт		10043-52-4-102-71-6	2400
100	Бетоны уян налархайжуулагч поликарбоксилат эфир	STRCH2-O-CH2ET,AIS1730-40(STRC=OES)	-	600
101	Бетоны барьцалдах хугацааг хурдасгагч диэтаноламин	HN(CH2CH2OH)2	111-42-2	1200
102	Бетоны барьцалдах хугацааг хурдасгагч магниийн силикат	Mg 99%	63800-37-3	190
103	Бетоны барьцалдах хугацааг хурдасгагч хөнгөн цагааны гидроксид	AO(OH)	21645-51-2	850
104	Бетоны барьцалдах хугацааг удаашруулагч натрийн гидроксид	NaC6H11O7	208-407-7,527-07-1	600
105	DPW-EVN-1920 Цуглуулагч бодис		97280-83-6	1800
106	DPW-EVN-1927 Цуглуулагч бодис		97280-83-6	1800
107	DPW-EVN-1928 Цуглуулагч бодис		97280-83-6	1800

108	DPW-EVN-1908 Хөөсрүүлэгч бодис		104-76-7;68609-68-7;94277-83-5	1800
109	DPW-EVN-1877 Хөөсрүүлэгч бодис		94277-83-5;104-76-7;97281-08-8;71-36-3;78-83-1;123-72-8	1800
110	Натрийн алюминат	NaAlO ₂	1302-42-7	150
111	Фтор силицилийн хүчил%	H ₂ SiF ₆	16961-83-4	150
112	Тетрагидроксиметил гликолурил	C ₈ H ₁₄ N ₄ O ₆	5395-50-6;6013-13-6	150
113	Кальцийн нитрат	Ca(NO ₃) ₂	13477-34-4	900
114	Натрийн ацетат	CH ₃ COONa	6131-90-4	60
115	Натрийн тиоцианит	NaSCN	540-72-7	60
116	Шингэн алдагдлыг бууруулах бодис	C ₆ H ₁₀ O ₅	9004-34-6	30
117	Биоцид	C ₈ H ₂₄ O ₁₂ P ₂ S	6131-90-4	30
118	Полимер		55566-30-8	30
119	Цооногийг тогтворжуулах бодис		-	30
120	Усанд уусдаг полимер		55566-30-8	30
121	Цооногийн хана бэхжүүлэгч бодис			90
122	Шингэн полимер			30
123	Шүүгдсийг бууруулах полимер		9004-32-4	30
124	Өрмийн шингэн найруулагч	C ₈ H ₁₅ NaO ₈	9004-32-4	30
125	Цуглуулагч бодис	aluminium sulfate	10043-01-3	30
126	Шингэн полимер			30
127	Аминжуулсан полимер			30
128	Эрдэст фибре			30
129	Угаалгын шингэн	Triethanolamine; (Trihydroxytriethylamine)	102-71-6; 7758-29-4; 68515-73-1	120
130	Аминжуулсан полимер		25987-30-8	30
131	Полимер	aluminium sulfate	10043-01-3	30
132	Боловсруулсан тос		68956-68-3	30
133	Тос		68956-68-3	30
134	Түлшний нэмэлт	CH ₄ N ₂ O	7732-18-5, 57-13-6	3
135	Калклерер П (Агаар хатаагч бодис)		5329-14-6,77-92-9, 95-14-7,202-394-1, 201-069-1	15
136	Альфа П-Эскале (Агаар хатаагч бодис)		5329-14-6,77-92-9, 95-14-7, 202-394-1, 201-069-1	15
137	Нимбэгний хүчил	C ₆ H ₈ O ₇	77-92-9	630
138	Бохир ус цэвэрлэгч нэмэлт	-	-	120
139	Бохир ус цэвэрлэгч нэмэлт	-	-	140

140	Зэврэлтээс хамгаалагч нэмэлт	-	-	115
141	Зэврэлтээс хамгаалагч нэмэлт	-	-	170
142	Моторын хөргөлтийн шингэн	-	107-21-1,12179-04-3,19766-89-3	65
143	Өнгө оруулагч бодис	-	8028-89-5	15
144	Чулуулаг хөрс нягтруулж бэхжүүлэх шахуурга резин	-	1344-09-8; 2855-13-2; 9016-87-9	2000
145	Уусгагч агуулаагүй эпокси цавуу	-	25068-38-6; 68609-97-2; 6972-7; 100-51-6; 2855-13-2	600
146	Ус үл нэвтрүүлэх мембран систем	-	64742-95-6; 1305-78-8; 8052-41-3; 91-08-7; 77-58-7; 14807-96-6; 8052-42-4; 64742-52-5; 95-63-6; 25551-13-7; 108-67-8	60
147	Үл агших цементэн зуурмаг	-	1305-78-8; 65997-15-1	600
148	Чулуулаг хөрс бэхжүүлэх полимер	-	1305-78-8	600
149	Уусгагч агуулаагүй эпокси чигжээс ба праймер	-	25068-38-6; 68609-97-2; 100-51-6; 2855-13-2	60
150	Уусгагч агуулаагүй уян хатан полиуретан эпокси мембран	-	25068-38-6; 26761-45-5; 84852-15-3; 6864-37-5; 9046-10-0	80
151	Шалны гадаргууг дүүргэгч хайрга	-	NA	120
152	Цементэн шалны системийн холбогч	-		1500
153	Бетон бэхжүүлэгч, тоос шороо үл нэвтрүүлэх шингэн	-	1344-09-8	140
154	Химийн бодист тэсвэртэй шалны бэхжүүлэгч	-	77-58-7; 108-32-7; 822-06-0; 28182-81-2	20
155	Шалны өнгөлгөөний зориулалттай чигжээс	-		20
156	Анионик флокулянт (Хатуу шингэнийг ялгагч бодис)	-	-	3550
157	Тос шингээгч материал		1318-02-1	10
158	Полиуретан будаг			40
159	Шалны гадаргууг дүүргэгч хайрга			100
160	Полиуретан будаг			40

161	Полиуретан будаг			40
162	Полиуретан будаг			40
163	Эпокси резин праймер			80
164	Эпокси резин праймер			80
165	Полиуретан будаг			80
166	Полиуретан будаг			80
167	Поликароксилатын эфир	-	27599-56-0; 7732-18-5	500
168	Барьцалдуулагч			400
169	Нүүрс барьцалдуулагч	Polyacrylamide	CAS 57-13-6	700
170	Зэс хандлагч	Aromatic substituted oxims	CAS 64742-47-8	20
171	Хар өнгөтэй жийргэвч хийх материалны бодис	Ultra black gasket maker 130Z CQ	471-34-1, 1317-65-3, 96-29-7, 1333-86-4	40
172	Чигжээс	Anaerobic flange sealant 50 ml	80-15-9, 98-82-8	5
173	Чигжээсний бодис	High performance thread sealant 50 ml	13463-67-7, 80-15-9, 98-82-8	5
174	Өндөр темпурт тэсвэртэй жийргэвчлний бодис	26BR high temp RTV red silicone gasket maker 3 OZ	7631-86-9	9
175	Гал унтраах даралтат шингэн бодис	3MTM NOVECTM 1230 Fire protection fluid (FK-5-1-12)	756-13-8	5
176	Зэс муудахаас хамгаалах тослох бодис	Copper anti-seize lubricant 8OZ	64742-54-7, 14807-96-6, 1317-65-3, 7440-50-8, 7782-42-5, 7631-86-9	25
177	Никелийг муудахаас хамгаалах тослох бодис	771 nickel anti lunricant 8 OZ BT	64741-96-4, 7782-42-5, 7440-02-0, 7429-90-5	25
178	Цэвэрлэгээний бодис	35V Prussian blue .75 OZ	8009-03-8, 14038-43-8	45
179	Зэвэрч муудахаас сэргийлсэн тосолгооны бодис	133K anti-seize lubricant 8OZ	1305-78-8, 7782-42-5, 7429-90-5, 64742-71-8	25



Зураг.2 Химийн агуулах.

2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1 УУР АМЬСГАЛ

Эх газрын эрс тэс уур амьсгалтай, жилийн 4 улиралтай, дэлхийн хамгийн “хүйтэн” улиралтай нийслэл хот юм. Хамгийн хүйтэн 1-р сарын дундаж агаарын температур -260С, хамгийн дулаан 7-р сарын дундаж агаарын температур +170С байдаг. Үнэмлэхүй хамгийн их температур 7-р сард +390С, хамгийн бага температур 1-р сард -400С хүрнэ. Агаарын жилийн дундаж харьцангуй чийгшил 61%. Салхи зонхилон хойд, баруун хойд зүгээс салхилна. Салхины жилийн дундаж хурд 2.4 м/сек. Сүүлийн 60 жилд Улаанбаатар хотын агаарын дундаж температур 2.0оС орчим нэмэгдсэн нь Монгол орны дунджаас (1.8оС) арай илүү байгаа бөгөөд энэ нь хотжилтоос хамааралтай. Уур амьсгалын дулаарлын улмаас хөрсний өнгөн хэсэг хатаж хуурайших үйл явц ихсэх хандлагатай байна. Уур амьсгал буюу нарны гэрэлтүүлэг, агаарын температур, чийгшил, даралт, салхины хурд, чиглэл, орох хур тунадасны хэмжээ, бичил цаг уур буюу хэдэн арван метрээс хэдэн зуун метрийн хязгаарлагдмал орчинд байгаа уур амьсгалын хүчин зүйлийн илэрцүүдийг хүн амын эрүүл мэндэд хэрхэн нөлөөлөх нөлөөллийг тооцож төлөвлөлтөөр шийдвэрлэх шаардлагатай бөгөөд буруу төлөвлөлт, байгуулалт, ашиглалтын явцад томоохон хотын хүрээлэн байгаа макро орчны уур амьсгалаас бичил орчны уур амьсгалын өөрчлөлтүүд үүсгэж буй хэд хэдэн нөхцөл шалтгаан байна. Тухайлбал: а) Хотын гудамж талбайн хучилт чулуу, асфальтаар дийлэнх нь хийгдсэн болон хар бүдэг өнгийн чулуун боржин өнгөлгөөтэй өндөр байшингууд ихсэхэд зуны улиралд хэт халж орчны агаарын температур ихэсч 1-3°С-ээр нэмэгдэх, зуны улиралд харьцангуй чийгшил 5-10%-иар буурах, өвөл хахирган хүйтний нөлөөлөл үзүүлдэг. б) Олон давхар барилга тухайн орон нутгийн зонхилох салхины чиглэлд перпендикуляр байрлалтай байхад агаарын хөдөлгөөнийг 2 дахин бууруулдаг. в) Агаарын утаажилт, тоосжилт, бохирдолт ихсэхэд бохирдсон агаарын тунаралт хотын дээр үүсэхэд нарны гэрлийн хэмжээ тухайлбал хэт ягаан туяаны цацраглалын хэмжээг 2050% хүртэл бууруулдаг. Иймд өдөрт 3 цагаас доошгүй хугацаанд нарны гэрэл тусч байхаар барилгын байршлыг чөлөөтэй задгай байдлаар төлөвлөх нь тухайн орчны бичил цаг уурын нөхцөлийг сайжруулах зуны бүгчим халууныг арилгах, агаарын чийгшлийг нэмэгдүүлэх нарны гэрлийн тусгалыг хүртээмжтэй болгох, улмаар агаар сэлгэлт салхижуулалтын дэглэмийг сайжруулах ач холбогдолтой. Хот суурингийн газрын гадаргын хөрс тухайн орчны бичил цаг уурын нөхцөлийг сайжруулах нарнаас ирсэн гэрлийн дулааныг шингээж халсан хөрсөнд үүссэн дулаанаас хөдөлгөөнт агаар шүргэх /конвекцийн/ замаар орчны агаар халах нөхцөлийг бүрдүүлнэ. Ургамлаар бүрхэвчгүй хөрс нь зуны улиралд халуун, өвлийн улиралд хүйтний нөлөө үзүүлдэг. Ил задгай ус, нуур, цөөрөм, усан сан, голын урсгал ус нь хот орчмын бичил цаг уурын нөхцөлийг сайжруулах зуны халуун улиралд агаарыг чийглэх, өвлийн улиралд мөсөн толио үүсгэж хүйтний температурыг нэмэгдүүлж агаарын даралтыг өөрчилж агаар шилжих, салхи үүсгэх ач холбогдолтой бөгөөд салхи үүсгэх нь бохирдсон агаарын тунаралыг зайлуулах экологи эрүүл ахуйн ач холбогдолтой байдаг.

2.2 АГААРЫН ЧАНАР

Улаанбаатар хотын хүн ам өсөн нэмэгдэж, төвлөрөлт ихэссэний улмаас хүн ам зүйн бодлого алдагдан агаарын бохирдлын өнөөгийн нөхцөл байдал нь хүн амын бохирдлын өртөлтийн түвшинг ихэсгэж, ноцтой байдалд хүрсэнг Дэлхийн Банк “Агаарын бохирдлын түвшин ба чанар эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг тогтоох судалгаа”-аар тогтоосон байдаг. Энэхүү судалгаагаар УБ хотод агаар чанарын хамгийн ихээр бохирдуулдаг эх үүсвэр нь тоосонцор болохыг харуулсан байна. УБ хотын хөрсөн дэх тоосонцорын PM2.5 бохирдлын үүсгэгч гол эх үүсвэр нь гэр хорооллын айл өрхийн зууханд түлсэн нүүрс, дулааны цахилгаан станцаас ялгарч буй чулуун нүүрсний хий болж байна. УБ хотын агаарын бохирдол ихтэй нэг хэсэг газрын тоосонцорын PM10 агууламжийн жилийн дундаж хэмжээний 50 хүртэл хувийг гудамж, замын гадаргуугаас ялгарч буй том ширхэглэгт тоос бүрдүүлдэг. Хүхэрлэг хийн /SO₂/ хэмжээ нь олон улсын стандартад заагдсан хэмжээнээс их байгаа ч хэмжээ болон нөлөөллийн зэрэглэлээр тоосонцор нь хамгийн их асуудал болж байна. Тоосны агууламжаар УБ хот нь дэлхийн хамгийн их бохирдолтой хотын тоонд багтдаг. УБ хотын хамгийн их агаарын бохирдолтой газруудад хийсэн хэмжилтийн үр дүнгээс харахад PM10 агууламжийн жилийн дундаж нь Монгол улсын болон олон улсын агаарын чанарын стандартаас 2-10 дахин их байна. PM2.5 агууламжид хийсэн хэмжилт харьцангуй бага байгаа ч агууламжийн хэмжээ агаарын чанарын стандартаас давсан байна. Өвлийн улирал нь харьцангуй богино хугацаанд тоосны агууламжийн цагийн болон өдрийн дундаж хэмжээг дээд түвшинд хүртэл нэмэгдүүлж, хот суурингийн газарт зөвшөөрөгдөх түвшин болон Монгол улс, олон улсын агаарын чанарын стандартын хэм хэмжээнээс даруй 4-14 дахин ихэсгэдэг байна.

2.3 ГАДАРГЫН УС

Хотын нутаг дэвсгэрийг дайран өнгөрөх 148 км урт Туул голд Асралт хайрхан уулнаас эх авсан Гачуурт, Тэрэлж, Толгойт, Улиастайн голууд цутгана. Туул голын ус хуримтлуулах ай сав 6300 м² талбайг хамрах бөгөөд голын үндсэн тэжээмж агаарын хур тунадас нь 90% байдаг байна. Мөн хот дундуур урсан өнгөрөх зүүн Сэлбийн гол нь Хэнтийн салбар уул болох Их Баян уулын өврөөс эх аван урсах ба өөрийнхөө гольдролын дагуу Хандгайт, Шарга морьт, Сэлх, Бэлх, Чингэлтэй, Ганц худгийн гол зэрэг олон жижиг цутгалтай голын сав газрыг үүсгэнэ. Улаанбаатар хотын хүн амын механикаар огцом өсөн, үйлдвэрлэл үйлчилгээ өргөжин хөгжиж байгаагаас цэвэр усны хангамж, бохир усны цэвэрлэгээ, гүний болон гадаргуугийн усан орчны бохирдол, нөөц, хангамж, хамгаалалтын асуудал нь онцгой анхаарах тулгамдсан асуудлын нэг болсон байна. Туул голын эх нь уулын тунгалаг, цэвэр, цэнгэг маш бага эрдэсжилттэй олон голууд цутгадаг, хүний үйл ажиллагааны нөлөө харьцангуй бага учраас, бохирдол бага, байгалийнхаа унаган төрхөөрөө байгаа юм. Харин нийслэлийн Налайх хот орчмоос эхлэн урсгалынхаа дагуу антропоген, техноген нөлөөлөлд өртөж, найрлага, шинж чанар нь өөрчлөгдөн, бохирдож байгалийн аясаар нөхөн сэргэх боломжгүй болж байна. Туул голын усны чанар найрлагыг үе үеийн судлаачид харьцангуй сайн судалж ирсэн байдаг. Туул голын эхийн цутгал голууд ихэвчлэн нэн цэнгэг буюу 100 мг/л хүрэхгүй маш бага эрдэсжилттэй, маш зөөлөн ихэвчлэн 1.0мг-экв/л хүрэхгүй хатуулагтай, хүний үйл

ажиллагаанд бага өртсөн уулын тунгалаг, цэвэр устай байснаа эрдэсжилт нь урсгалынхаа дагуу алгуур өсөж, түүнчлэн Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжаас гарсан бохир ус нийлснээс дооших хэсэгт бохирдолтын үзүүлэлтүүд эрс огцом нэмэгдэж “Бохирдолттой, маш их бохирдолтой” гэсэн ангилалд шилжиж, голын усны бохирдол эрс ихсэж байгаа нь ТЦБ-ийн хэвийн бус үйл ажиллагаанаас шалтгаалж байгаа нь илт байна. Туул голын усны чанар Хиагт голын Алтанбулагийн цэгийн орчимд голын ус урьдын адил бохирдол их, усны бохирдлын индекс 2015 онд 15.89, 2016 онд 17.18, Сонгиноос Хаданхясаа хүртэлх хэсэгт мөн индекс 2015 онд 13.44-48.78 байсан бол 2016 онд 8.66-21.1 буюу дунджаар 2 дахин буурч, Алтанбулагийн гүүрийн орчимд усны бохирдол бага зэрэг буурч бохир ангиллаас бохирдолтой ангилалд шилжсэн байна. Лүнгийн орчимд Туул голын усны чанар сайжирч цэвэр гэж үнэлэгджээ.

2.4 ГАЗАР ХӨДЛӨЛ

Өмнөх үеийн судалгааны аргачлалын дутагдалтай тал нь газар хөдлөлийн давтагдалтын үе болон түүнээс үүсч болох аюулын үнэлгээг тооцож оруулдаггүй байсан байна. 2001 оноос эхлэл нь тавигдаж, 2005-2008 онд Одон орон Геофизикийн судалгааны төвд хийлгэсэн Улаанбаатар хотын газар хөдлөлтийн бичил мужлалын зураглалын судалгааны ажлыг өнөө үеийн дэлхийн түвшинд хэрэглэж байгаа судалгааны аргачлалын дагуу хийж мэдээллийн санг баяжуулан Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн газар хөдлөлийн аюулын үнэлгээний талаар өмнө хийгдсэн ажлуудыг улам нарийвчлан сайжруулсан гэж дүгнэж байгаа бөгөөд хамгийн их чичирхийллийн хэмжээг 8 балл байхаар тогтоосон.

2.5 ХӨРСӨН БҮРХЭВЧ

Агуулахын нутаг дэвсгэрт бага зэргийн бохирдолтой, техносол хөрстэй, гадаргуугийн 60-70 % нь барилга байгууламж, хатуу хучилттай зам талбайтай. Хөрсний чанар: Улаанбаатар хотын хөрс дэх хүнд металлын агууламжийг хөрсний чанарын MNS 5850:2008 стандарт (цаашид ХЧС гэх) дахь зөвшөөрөгдөх дээд хэмжээ (ЗДХ)-тэй харьцуулахад, стандартын түвшинд байгаа боловч, зарим цэгт стандартаас хэд дахин их бохирдсон байна. Тухайлбал, Хан-Уул дүүргийн үслэг эдлэлийн үйлдвэр, Харгиа (47053”31.6”, 106053”32.5”) цэвэрлэх байгууламжийн орчимд хромын агууламж 612.4мг/кг буюу ЗДХ-ээс 4 дахин их буюу аюултай агууламжид хүрч бохирдсон байна. Хан-Уул дүүргийн хөрсөнд агуулагдаж буй дундаж агууламж нь кадми 0.3 мг/кг, хартугалга 16.6 мг/кг, мөнгөн ус 0.5 мг/кг, бром 1.2 мг/кг, хром 38.7 мг/кг, цайр 163.7мг/кг, зэс 27.7 мг/кг, кобальт 26.1 мг/кг, стронций 520.9 мг/кг байжээ. Улаанбаатар хотын хөрсний бохирдол ихсэх хандлагатай байгаа нь хатуу хог хаягдал, авто машин засварын газар, үйлдвэр, гэр хороолол, химийн бодисын зохисгүй хэрэглээтэй шууд холбоотой юм. Тухайлбал, арьс ширний үйлдвэрийн хаягдал, нүүрсний шаталтаас үүссэн мөнгөн ус, ландфилл дэх хог, хаягдал зэрэг эх үүсвэрүүд байна. Судалгааны үед агуулахын талбайн хөрснөөс авсан дээжийг Байгаль орчин, хэмжилзүйн төв лабораториор хөрсний хүнд элемент шинжлүүлсэн. Шинжилгээгээр кобальтын агууламж стандартаас их гарсан ба бусад элементүүд нь “Хөрсний чанар, Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” MNS5850:2008 стандартаас давсан үзүүлэлт байхгүй

хэвийн хэмжээнд байна.

2.6 УРГАМЛАН БҮРХЭВЧ

Үйлдвэр орчмын газар нь барилга байгууламж, зам тээврийн сүлжээ, машин техникийн хөдөлгөөний улмаас унаган ургамлан нөмрөг устаж үгүй болсон.

2.7 ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТАГ

“МСМ групп” ХХК-ийн “Химийн бодисын агуулах”-тэй Богдхан уулын дархан цаазат газрын хамгийн ойр хилийн цэг нь урд зүгт 450м зайтай байна.

2.8 ТҮҮХ СОЁЛ, АРХЕОЛОГИЙН ДУРСГАЛТ ЗҮЙЛС

Агуулахын үйл ажиллагаанд хамаарах талбай болон түүний орчмын нутагт нь түүх соёлын дурсгалд тооцож болохуйц газар болон археологийн болон палеонтологийн олдвор байхгүй болно. Цаашид барилга байгууламж нэмж барих, өргөтгөх явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрсэн үед “Монгол Улсын Үндсэн хууль”-ийн I бүлгийн 7-р зүйлд “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” гэж заасны дагуу түүх, соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулахтай холбоотой үүрэг хариуцлагаа мөрдөж ажиллах нь зүйтэй.

СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Төслийн үйл ажиллагааны сөрөг нөлөөллүүд нь хөрсний эвдрэл, бохирдол, ажиллагсдын ажлын байрны орчин (гэрэлтүүлэг, чимээ шуугиан, чийгшилт, тоосжилт, мэргэжлээс шалтгаалах өвчлөл зэрэг) химийн зарим бодис болон тоног төхөөрөмжийн болон авто засварын үйлчилгээнд ашиглагдах тос, тослох материалыг хөрсөнд асгаснаас үүдэх хөрсийг бохирдуулах бохирдол байх ба бохир усны худгууд дамжуулах шугам хоолойн найдваргүй байдлаас болж бохир ус хөрсийг бохирдуулах, ахуйн хог хаягдал салхиар хийсэн орчныг бохирдуулах, болгоомжгүй байдлаас гал түймэр гарах зэрэг асуудал байна. Тус агуулахын талбайн хөрснөөс авсан дээжийг Байгаль орчин, хэмжилзүйн төв лабораториор хөрсний хүнд элемент шинжлүүлсэн.

Шинжилгээгээр кобальтын агууламж стандартаас их гарсан ба бусад элементүүд нь “Хөрсний чанар, Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” MNS5850:2008 стандартаас давсан үзүүлэлт байхгүй хэвийн хэмжээнд байна. Гэвч тус агуулах нь кобальт агуулсан ямар нэгэн бодис материал ашигладаггүй, нөгөө талаас Улаанбаатар хотын үйлдвэрийн бүс орчимд хүнд элементийн агуулга ерөнхий байдлаараа их болсон зэргээс үзвэл энэхүү кобальтын бохирдол нь агуулахын үйл ажиллагаатай хамааралгүй хэмээн дүгнэхэд хүргээд байна. Тус агуулах нь усыг технологийн зорилгоор ашиглахгүй, ус бохирдуулах ямар нэгэн үйл ажиллагаа явуулахгүй тул усаар дамжин хүн болон байгальд үзүүлэх эрсдэлгүй байна.

Агуулахын барилга, байршил нь MNS 6458:2014 стандартын шаардлагыг хангасан тухай мэргэжлийн хяналтын байцаагчийн дүгнэлттэй. “МСМ групп” ХХК нь бодис материалыг агуулахад хадгалахдаа шинж чанараас нь хамааруулан ангилан хураадаг байна. Агуулахын агааржуулалтыг сайжруулах байгалийн болон албадмал

агааржуулалтын систем суурилуулах, бодис материалыг ангилан хураасны дараа харгалзах тэмдэг тэмдэглэгээ хийх шаардлагатай.

Химийн бодисын сав баглаа боодлыг цаашид хэрхэн устгалд оруулах талаар төлөвлөгөө боловсруулан ажиллах, устгах хоргүйжүүлэх талаар санал санаачлага гарган зохих эрх бүхий байгууллагуудад танилцуулах шаардлагатай байна.

Ажилчидын буруу үйл ажиллагаа, санамсар болгоомжгүй байдал, байгалийн хүчин зүйлээс хамаарч агуулахад аюул осол тохиолдсон үед нөхөж баршгүй хохирол үүсэх тул аюулгүй ажиллагааг дээд зэргээр ханган ажиллах, аюул тохиолдсон үед авах арга хэмжээг нарийн тодорхой болгох шаардлагатай байна.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1 ЦАГ УУР, УУР АМЬСГАЛЫН НӨХЦӨЛД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ

Монгол орны уур амьсгалын эрс тэс байдал нь химийн бодисын агуулах болон бодисын тээвэрлэлт, хадгалалтад дараах төрлийн нөлөөллүүд учруулж болзошгүй.

Үүнд:

- Химийн бодисын хадгалалтын горим хангахгүй нөхцөлд хадгалбал хэт хөрснөөс талсжих, халснаас ууршиж дотоод даралт нэмэгдэх, дулаанд тогтворгүй бүтээгдэхүүн үүсэх, нарны гэрэл болон хэт ягаан туяанаас исэлдэх, полимержих зэргээр бүтээгдэхүүний шинж чанар өөрчлөгдөх, өндөр температурт хэт халснаас тэсэрч, дэлбэрэх, галын аюул гарах, бүтээгдэхүүний чанар өөрчлөгдөх, асгарч алдагдах.
- Шингэн төлөвтэй бодисууд дулааны нөлөөгөөр тэлэх, улмаар хальж асгарах
- Хадгалах температурын өөрчлөлт, хэт их халалтаас шалтгаалан найрлага шинж чанарт өөрчлөлт орох
- Аянга цахилгаан, гэнэтийн хүчтэй цахилгаан гүйдлийн нөлөөгөөр тэсэрч дэлбэрэх зэрэг болно.

ДҮГНЭЛТ

Химийн бодисын тээвэрлэлт, хадгалалтаас уур амьсгалд үзүүлэх нөлөөлөл нь 100 % маш бага буюу нөлөөгүй байгаа бөгөөд харин тохиолдох магадлал нь ховор гэсэн ангилалд хамрагдаж байна. Цаг уур, уур амьсгалд үзүүлж болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, ялангуяа Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан болзошгүй осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажилласан тохиолдолд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх боломжтой юм.

3.2 АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЭХ ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, ҮНЭЛГЭЭ

Химийн бодисын хадгалалт, тээвэрлэлтээс агаарын чанарт хэдэн хүчин зүйлсээр нөлөөлөл үзүүлж болзошгүй. Эдгээр нь химийн бодисын тээвэрлэлт, хадгалах үед гадаад орчны болон ажлын байрны агаарын чанар, найрлагыг өөрчилж болзошгүй байдлаар тодорхойлогдоно.

Үүнд:

- Химийн бодисын агуулахад химийн бодистой харьцан ажиллах үед санамсаргүй асгах, алдах, агуулахын шал, гадаад орчинд асгарсанаас ажлын байрны орчны агаарт нөлөөлөх.

- Химийн хорт болон аюултай бодис агуулж байгаа сав нь хэт удаан хадгалах, нарны гэрэл тусах, хөлдөх, халах, зэврэх, урвалд орох зэргээс эвдрэх, цоорох, зөөлрөх зэрэг гэмтлээс шалтгаалан асгарч алдагдах, ажлын байрны агаарт тархах.
- Химийн хортой болон аюултай бодисыг гадна талбайд ил задгай хаяснаас агаарт тэсрэмтгий хольц үүсгэх, гадаад орчинд агаарын урсгалаар дамжин нөлөөлөх.
- Химийн бодисын тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдсанаас ууршимтгай, дэгдэмхий бодисууд агаарт уурших, исэлдэн урвалдах зэргээр агаарын чанар найрлагад нөлөөлөх.
- Химийн бодистой шатах, гал авалцах эх үүсвэрийг ойр байлгаснаар гал түймэр гарах, тэсэрч дэлбэрснээр хортой хий ялгаран агаарын чанар, хүний эрүүл мэндэд нөлөөлөх
- Тухайн бодисыг хадгалах үед хор аюулын лавлах мэдээлэлд заасан хадгалах нөхцөлийг хангасан орчныг агуулахад бүрдүүлээгүйгээс агаарын найрлага өөрчлөгдөх, улмаар хүний эрүүл мэндэд нөлөөлөх зэрэг болно.

ДҮГНЭЛТ

Химийн бодисын хадгалалт, ашиглалтаас агаарын чанарт үзүүлэх нөлөөллийн эрчим, цар хүрээгээр 100 % бага, маш бага буюу нөлөөгүй байгаа бөгөөд дохиолдох магадлалаар авч үзвэл 66.6% нь ховор байна. Гэхдээ химийн бодисын агуулахад химийн бодистой харьцан ажиллах үед санамсаргүй асгах, алдах, агуулахын шал, гадаад орчинд асгарсанаас ажлын байрны орчны агаарт нөлөөлж болзошгүй тул нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн тохиолдолд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх боломжтой.

3.3 ХӨРСӨН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Төслийн хэмжээнд хэрэглэгдэх химийн бодисуудаас хөрсний чанарт цөөн хэдэн хүчин зүйлсээр нөлөөлж болзошгүй. Химийн бодис нь газрын хөрсөнд стандартад заасан хэмжээнээс ихээр хуримлагдвал хөрсний ус ургамлаар дамжин нутгийн оршин суугчдын амьдрах орчин, хөрсний бичил биетэн, биосферт муугаар нөлөөлөх тул бодис тус бүрийг тээвэрлэх, хадгалах нөхцөлийг хангах шаардлага тавигдана.

Химийн бодисуудын тээвэрлэлт, хадгалалтаас үүсэж болзошгүй нөлөөллүүдийг доор үзүүлэв.

Үүнд:

- Химийн бодисын агуулахын барилгын хийц, инженерийн байгууламжийн төлөвлөлт, гүйцэтгэлийн доголдол, химийн бодисын хадгалалтын горим алдагдсанаар хөрсөнд их хэмжээгээр шингэх, хөрсөн бүрхэвчинд сөрөг нөлөөлөх.
- Химийн бодис тээвэрлэх, хадгалах үйл ажиллагааг шаардлагын дагуу зөв явуулаагүйгээс химийн бодисыг хөрсөнд алдаж, түүний найрлага бүтцийг өөрчлөх
- Хөрсөнд их хэмжээний химийн бодис алдагдсанаар ургамалжилт, хөрсний бичил биетэнд дам нөлөөлөл үзүүлэх зэрэг болно.

ДҮГНЭЛТ

Химийн бодисын агуулах болон бодисын хадгалалт, тээвэрлэлтээс хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөлөл 100% маш бага буюу нөлөөгүй байгаа бөгөөд дохиолдох магадлалаар нь авч үзвэл ховор тохиолдох магадлалд орж байна.

3.4 ГАДАРГЫН БОЛОН ГАЗРЫН ДООРХ УСАНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, ҮНЭЛГЭЭ

“МСМ Групп” ХХК-ийн Химийн бодисын агуулах нь зөвхөн хадгалалтын үйл ажиллагаа явуулах бөгөөд агуулахын ажлын байрны барилгын хийц, инженерийн байгууламжийн төлөвлөлт, гүйцэтгэлийг сайтар ханган ажиллах шаардлагатай.

Төслийн үйл ажиллагаанаас усны чанар, найрлагад химийн бодисуудын тээвэрлэлт, хадгалалтаас дараах төрлийн нөлөөллүүд үүсэж болзошгүй. Үүнд:

- Химийн бодисын агуулахын барилгын хийц, инженерийн байгууламжийн төлөвлөлт, гүйцэтгэлийн доголдоос үүдэн газрын гадаргад химийн бодис алдагдах, улмаар түүний урсцаар тархаж, голдирлын дагуух усыг бохирдуулах.
- Усан орчинд богино хугацааны хурц хоруу чанартай, усны амьд организмд хортой зэрэглэлд хамаарах бодисын хадгалалт, ашиглалтыг зохих журмын дагуу явуулаагүйгээс усан орчинд нөлөөлөх.
- Тээвэрлэх, хүлээн авах үйл ажиллагааг шаардлагын дагуу зөв явуулаагүйгээс химийн бодисыг түр урсцын голдирлуудад асгах, талбайд татан ирэх явцад бохирдлын эх үүсвэрийг бий болгох зэрэг болно.

ДҮГНЭЛТ

Химийн бодисын хадгалалт, ашиглалтаас усны чанар найрлагад үзүүлэх нөлөөлөл 100 % бага, маш бага буюу нөлөөгүй байгаа бөгөөд тохиолдох магадлалын 66.6% нь ховор тохиолдохоор байна. Тухайн төслийн хувьд анхаарах гол асуудал нь химийн бодисыг тээвэрлэх, хүлээн авах үйл ажиллагааг шаардлагын дагуу зөв явуулаагүйгээс химийн бодисыг түр урсцын голдирлуудад асгах, талбайд татан ирэх явцад бохирдлын эх үүсвэрийг бий болгох нөхцөлтэй байна. Тиймээс химийн бодисын тээвэрлэлт, нийлүүлэлт хийх үедээ татан авчрах, ачиж тээвэрлэх асуудлыг зохих журмын дагуу явуулсан тохиолдолд нөлөөлөл үзүүлэхгүй байх боломжтой байна.

3.5 УРГАМЛАН НӨМРӨГТ ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, ҮНЭЛГЭЭ

Төсөл хэрэгжих орчны ургамлан нөмрөг химийн бодисын тээвэрлэлт, хадгалалтаас үүдэлтэй нөлөөлөлд автах, доройтох нь бага боловч зарим төрлийн осол аваар, техникийн аюулгүйн ажиллагааны алдаанаас шалтгаалан шууд болон дам сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй байна. Үүнд:

1. Тээвэрлэх болон агуулахад татан авчрах, хадгалалтын горим зөрчигдсөнөөр химийн бодис хөрсөнд нэвчиж, ургамалжилтад нөлөөлөл үзүүлэх, бохирдуулах
2. Осол аваарын үед техникийн гаралтай бохирдуулагч хөрсөнд нэвчиж, ургамалжилтад нөлөөлөл үзүүлэх, бохирдуулах зэрэг болно.

ДҮГНЭЛТ

Химийн бодисын агуулах болон бодисын хадгалалт, тээвэрлэлт, ашиглалтаас ургамлан бүрхэвчинд үзүүлэх нөлөөлөл 100 % маш бага буюу нөлөөгүй байгаа бөгөөд тохиолдох магадлал нь ховор байна. Химийн бодисуудын тээвэрлэлт, хадгалалтаас үүсэх болзошгүй нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажилласан тохиолдолд ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл бага юм.

3.6 АМЬТНЫ АЙМАГТ ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, ҮНЭЛГЭЭ

Осол аваарын үед техникийн гаралтай бохирдуулагч хөрсөнд нэвчиж, ургамалжилтад нөлөөлөл үзүүлэх, бохирдуулсан тохиолдолд доорх байдлаар амьтны аймагт нөлөөлж болзошгүй юм. Үүнд:

- Бодисыг гадаргууд алдсан тохиолдолд их хэмжээний бодисоор бохирдсон ургамлыг мал, амьтан идсэнээр хордох.
- Алдагдсан бодис хөрсөнд шингэснээр амьтад, бичил биетэн бодисоор хордох, үхэлд хүрэх зэрэг болно.

ДҮГНЭЛТ

Химийн бодисын хадгалалт, ашиглалт, тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл 100 % маш бага буюу нөлөөгүй байгаа бөгөөд дохиолдох магадлал нь ховор байна.

3.7 ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДЭД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, ҮНЭЛГЭЭ

Химийн бодисын агуулахад хүний эрүүл мэндэд эрсдэл үүсгэж болзошгүй эх үүсвэр нь нэр бүхий 57 төрлийн химийн нэгдэл агуулсан 95410 тн 31250 ширхэг бүтээгдэхүүн бөгөөд аюулгүй ажиллагааг хангаж ажиллаагүй нөхцөлд химийн бодисууд нь эрсдэл үүсгэх шууд эх үүсвэр болно.

Химийн бодисыг тээвэрлэх, хадгалах үйл ажиллагааны явцад эрсдэл үүсэх эсэх нь тухайн химийн бодистой харьцан ажиллаж буй хүнээс шууд хамааралтай байдаг. Өөрөөр хэлбэл агуулахад ажиллаж 6 хүний хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг ханган ажиллахаас үүсэж болзошгүй эрсдэл нь шууд хамааралтай юм. Нөгөө талаар эрсдлийн шинж чанар, цар хүрээнээс хамааран агуулахын ажилчид болон Хан-Уул дүүргийн оршин суугчид эрсдэлд өртөгч болно. Ялангуяа химийн бодисуудтай харьцан ажиллах 6 ажилтан илүүтэйгээр өртөж болзошгүй юм.

Аливаа химийн бодисын бохирдол эх үүсвэрээс хөрс, ус, агаарт алдагдаж тухайн орчны ургамал, амьтныг хордуулахаас гадна хүнсний бүтээгдэхүүнд шингэж, хуримтлагдаж тухайн бохирдсон хөрс, ус, агаараар амьсгалах, хүрэлцэх, мөн бохирдсон хүнсний бүтээгдэхүүнийг хэрэглэх зэрэг замуудаар хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг. Химийн бодисын бохирдлын хүний эрүүл мэндэд нөлөөлөх нь бодисын тун хэмжээ, тухайн бодисын шинж чанар, биозадралд орох чадвар, хуримтлагдах чадвар зэрэг хүчин зүйлсээс хамаардаг.

Өөрөөр хэлбэл нэр бүхий 57 төрлийн химийн нэгдэл агуулсан 95410 тн ,31250 ширхэг бүтээгдэхүүний тээвэрлэлт, хадгалалт аюулгүйн дүрмийг сайтар баримталж ажиллаагүй бол ажиллагсдын эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй. Иймд химийн бодистой харьцаж ажиллах ажилтнууд нь энэ чиглэлийн мэргэжлийн хүн байх заавал шаардлагатай.

Харин химийн бодисын тээвэрлэлт, хадгалалтын явцад хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй нөлөөллийг нэгтгэн авч үзье.

Үүнд:

- Химийн бодисын агуулахын барилгын хийц, инженерийн байгууламжийн төлөвлөлт, гүйцэтгэлийн доголдлоос үүдэн аюул, осол гарах.
- Мэргэжилтэн, ажилтны чадваргүй байдал, хариуцлагагүй үйлдэл, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангаж ажиллаагүйгээс ажлын байранд химийн бодис алдагдах, хүний эрүүл мэндэд нөлөөлөх.
- Үйлдвэрлэгчээс гаргасан хор аюулын лавлах мэдээллийг үндэслэн химийн бодис, бүтээгдэхүүн эсвэл химийн бодис хадгалах үйл ажиллагааг нэг бүрээр боловсруулж мөрдөөгүйгээс аюулгүй байдал алдагдах, хүний эрүүл мэндэд нөлөөлөх.
- Химийн бодисыг хамт хадгалж болохгүй бодис болон зориулалтын бус орчин, агуулахад хадгалснаас хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлэх.
- Химийн бодисыг хадгалах үйл ажиллагаа нь хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны нөхцөл, шаардлагыг бүрэн хангасан зориулалтын байр, талбай,

ослын үед ажиллах арга хэмжээний төлөвлөгөөгүй ажилласнаас хүний эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчинд хохирол үүсэх.

- Химийн бодистой харьцаж ажиллах ажиллагсад нь зохих шатны сургалтад хамрагдаагүй, зохих мэдлэг дадлыг эзэмшээгүйгээс химийн бодистой харьцаж ажиллах хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг зөрчих, хордох.
- Химийн бодисын агуулахад хор аюулын лавлах мэдээлэлд заасан болзошгүй аюул, ослын үед ашиглах багаж хэрэгсэл, материалыг ажлын байранд байршуулж, ажиллагсдад ажиллах дадлыг эзэмшүүлээгүйгээс хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учрах.
- Бодис нь хэвийн нөхцөлд тогтвортой боловч өндөр температурт шатах, хүчтэй хүчлүүдтэй урвалд орвол аюултай бодис тул харьцах үедээ хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангаж ажиллаагүйгээс асгарч алдагдах, хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөл үзүүлэх зэрэг болно.

ДҮГНЭЛТ

Химийн бодисын хадгалалт, ашиглалтаас хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн 62.5% нь бага, маш бага буюу нөлөөгүй байгаа бөгөөд тохиолдох магадлалын 50% нь ховор тохиолдохоор байна. Харин нийт нөлөөллийн 37.5% нь нөлөөллийн эрчим цар хүрээгээр дунд гэсэн ангилалд орж байгаа бөгөөд тохиолдох магадлалаар нь авч үзвэл магадгүй болон боломжтой ангилалд орж байна. Учир нь тус байгууллага нь үйлдвэрлэгчээс гаргасан хор аюулын лавлах мэдээллийг үндэслэн химийн бодис, бүтээгдэхүүн эсвэл химийн бодис хадгалах үйл ажиллагааг нэг бүрээр боловсруулж мөрдөөгүйгээс аюулгүй байдал алдагдах, хүний эрүүл мэндэд нөлөөлөх, химийн бодистой харьцаж ажиллах ажиллагсад нь зохих шатны сургалтад хамрагдаагүй, зохих мэдлэг дадлыг эзэмшээгүйгээс химийн бодистой харьцаж ажиллах хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг зөрчих, хордох, химийн бодисын агуулахад хор аюулын лавлах мэдээлэлд заасан болзошгүй аюул, ослын үед ашиглах багаж хэрэгсэл, материалыг ажлын байранд байршуулж, ажиллагсдад ажиллах дадлыг эзэмшүүлээгүйгээс хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учрах эрсдэлтэй байгаа тул хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг сайтар ханган ажиллах шаардлагатай. Дээрх арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажилласан тохиолдолд химийн бодисын хадгалалтаас хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх боломжтой байна.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Энэхүү химийн бодисын агуулахын байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт нь:

Үйл ажиллагаагаа явуулахдаа байгаль орчинд учрах сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, замаар байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулахад оршино.

- ❖ Байгаль орчны ISO 14001 стандартыг байгууллагадаа хэрэгжүүлж эхлэх, баталгаажилтыг олон улсын эрх бүхий гадны байгууллагаар хийлгэх.
- ❖ БОМТ-нд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан ажиллагсдын үүрэг хариуцлагыг тогтоосон удирдлагын шатлал дараалал бий болгох.
- ❖ Ажиллагсад нэг бүр байгаль орчныг хамгаалах асуудалтай холбоотой үүрэг хариуцлагаа бүрэн ойлгосон байхын зэрэгцээ тэдэнд үүргээ биелүүлэхэд нь

туслах бэлтгэл сургалтанд хамрагдсан ур чадвартай мэргэжилтэнтэй болох.

- ❖ Байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдэлийг урьдчилан тооцсоноор байгальд шууд болон шууд бус хэлбэрээр үзүүлэх нөлөөллийг бууруулах, байгаль орчны төлөв байдлыг сайжруулах, хэвийн хадгалж, хамгаалах.
- ❖ Орон нутгийн удирдлага, хяналтын байгууллага, иргэдтэй байгаль хамгаалах асуудлаар зөвлөлдөж тэдний саналыг авч хамтран ажиллах.
- ❖ Байгаль орчин хамгаалах сөрөг нөлөөллийг багасгах талаар ажиллагсдад зааварчилгаа өгч сургалт, сургалтын материалаар хангах
- ❖ Байгаль орчны менежментийн асуудлаар БОННУ-ний тайланд тусгагдсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх.

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Арга хэмжээ	Хамрах хүрээ	Тайлбар	Ажлын биелэлт
1	Орчны тоосжилтыг бууруулах зорилгоор компанийн талбай доторх хатуу хучилтгүй талбай, тээврийн хэрэгслийн зогсоол болон зүлэгтэй хэсгүүдэд тогтмол усалгаа хийх	Агуулахын талбай	2022 ОНЫ 5 дугаар сарын эхэн үеэс эхлэн 9 дүгээр сарын дунд үе хүртэл байгууллагын химийн бодисын агуулахын гадаах зүлэгжүүлсэн талбайд байнгын усалгаа хийсэн.	100%
2	Төслийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх автомашин, тоног төхөөрөмж, механизмын техникийн хэвийн ажиллагааг болон шатах тослох материалын зохистой хэрэглээг хангах	Тээвэрлэлт үйлчилгээнд ашиглагдаж буй тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжүүд	Улирал бүр төслийн өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглагдаж буй тээврийн хэрэгслүүд болон тоног төхөөрөмжүүдэд урсгал засвар үйлчилгээ хийдэг бөгөөд өдөр тутамд ашиглахын өмнөх үзлэг шалгалт хийдэг бөгөөд шатах тослох материалуудыг зориулалтын тусгаарлсан цэгт хадгалдаг.	100%
3	Химийн бодистой харьцах үеийн аюулгүй ажиллагааны горимыг чанд мөрдөх, ажиллагсдад химийн бодистой харьцаж ажиллах талаар заавар зөвлөгөө тогтмол өгөх, шаардлагатай нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангаж өгөх	Агуулахын ажилчдад	Химийн бодистой харьцаж ажилладаг ажилчид өдөр бүр ажил эхлэхийн өмнө Аюулгүй ажиллагааны уулзалт хийж ахлах ажилтнуудаасаа холбогдох зааварчилгааг авч АА-ны журам, сэдэв уншиж бусадтайгаа хуваалцаж, бүртгэлийн хуудсанд гарын үсэг зурж ажлаа эхлүүлдэг. МСМ групп ХХК-ний ХАБЭА-н баг дээрх АА-ны уулзалтуудад өдөр бүр оролцож хяналт тавин ажилладаг.	100%

4	Агаарын мониторинг хийх	Агуулахын дотоод, гадаад орчин	Агаарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний дагуу 2022 оны агаарын мониторинг хийх ажлыг БОХШХ 2022-д багтаасан болно. БОХШХ- ийг сонгон шалгаруулалт явуулж “Ногоон титэм” ХХК -ийг сонгон холбогдох дурэм журмын дагуу БОХШХ-ийг амжилттай хийлгэсэн.	100%
ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСӨН БҮРХЭВЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ				
5	Хөрсний мониторинг	Төслийн талбай	2022 оны хөр мониторинг хийх ажлыг БОХШХ 2022-д багтаасан болно. БОХШХ- ийг сонгон шалгаруулалт явуулж “Ногоон титэм” ХХК -ийг сонгон холбогдох дурэм журмын дагуу БОХШХ-ийг амжилттай хийлгэсэн.	100%
6	Химийн бодис болон цахилгаан үүсгэврээс түлш тос асгарч, гоожихоос сэргийлсэн “Асгаралтаас сэргийлсэн далантай” болох	Агуулах	Химийн бодисын болон цахилгаан үүсгэврээс түлш, тос асгарсан үед хөрсөнд шингэхээс сэргийлсэн асгаралтын эсрэг хана 2 газар хийсэн.	100%
УСНЫ ЧАНАРТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ				
7	Усны мониторинг хийх	Агуулах	Усны чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний дагуу 2022 оны агаарын мониторинг хийх ажлыг БОХШХ 2022-д багтаасан болно. БОХШХ- ийг сонгон шалгаруулалт явуулж “Монгол-Ус” ТӨҮГ -ийг сонгон холбогдох дурэм журмын дагуу БОХШХ-ийг амжилттай хийлгэсэн.	100%

5.1 АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ

- Химийн бодис хадгалах агуулах байрыг стандарт шаардлагын дагуу дулааны тусгаарлалт хийсэн.
- Химийн бодисын хаягдал, үлдэгдэл гарсан тохиолдолд үйлдвэрийн хаягдал материал устгах мэргэжлийн байгууллагад хандаж устгуулахаар “Цэцүүх Трейд ХХК”-тай гэрээ байгуулан хамтарч ажиллаж эхэлсэн.
- Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах тээврийн хэрэгслийн орчны агаарт ялгаруулах хийн хаягдлын ялгаралтыг багасгахын тулд засвар үйлчилгээ тогтмол хийдэг бөгөөд ашиглалтын хугацаа дууссан тээврийн хэрэгсэл ашигладаггүй болно.

5.2 ХӨРСӨН БҮРХЭВЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ

- Төслийн үйл ажиллагаа нь орчны суурьшил нягтрал, хүрээлэн буй орчны даац, хэвийн байх нөхцөлийг алдагдуулахгүй байхаар төлөвлөгдсөн.
- Төслийн аль ч шатанд (үүнд төсөл хэрэгжиж дууссаны дараах үе ч хамаарна) төслийн талбай болон түүний ойр орчимд олон салаа зам гаргаж, хөрсийг элэгдэл, эвдрэлд оруулах, бохирдуулахаас сэргийлж зам талбайн

тэмдэгжүүлэлтийг зохих заавар журмын дагуу хийж гүйцэтгэсэн.

- Хашаа, хязгаараас гадна элдэв хог хаяхгүй байх, газрын төрх, төслийн талбайг эвдэхгүй, хөндөхгүй байх арга хэмжээг хэвшүүлэн ажиллаж байна.
- Химийн бодисын агуулахыг ус нэвчүүлэхгүй байхаар тохижуулан ус хуримтлуулах суваг татсан.
- Химийн бодисын агуулахад тогтмол /өдөр бүр, 7 хоног бүр/ үзлэг хийж хяналт тавьж ажилладаг.
- Хөрс болон усан орчинд химийн бодис алдагдсан тохиолдолд тухайн бодисыг цаашид тархахаас сэргийлж, алдагдсан бодисын шинж чанараас хамааруулан шингээж авах, саармагжуулан хоргүйжүүлэх арга хэмжээг цаг алдалгүй авах элс шороо зэрэг элбэг байх материалыг ашиглахаас гадна Австрали улсад үйлдвэрлэсэн ОУ-ын стандартын шаардлага хангасан 240л - ийн хүчин чадал бүхий нийт 10 ширхэг шингээх хэрэгслийн иж бүрдлийг ажлын байруудад байрлуулсан болно.
- Химийн бодисын болон цахилгаан генератораас түлш, тос асгарсан үед хөрсөнд шингэхээс сэргийлсэн асгаралтын эсрэг хана, далан 2 газар хийсэн.



Зураг 3. Генераторын асгаралтын эсрэг.



Зураг 4. Бетон нэмэлтийн үйлдвэрийн асгаралтын хана.

5.3 УРГАМЛАН НӨМРӨГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ

- Химийн бодисын аюулгүй ажиллагаа, түүнийг зөрчсөнтэй холбоотой осол аварь нь голдуу техник технологийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагааны горим алдагдсанаас үүдэлтэй байдаг ба тээвэрлэх болон хадгалалтын буруу үйл ажиллагаанаас шалтгаалсан ургамалжилтанд үзүүлэх сөрөг нөлөөлөл давамгайлдаг учраас химийн бодис тээвэрлэх, хадгалах, ашиглах журманд заасны дагуу ямагт асгахаас сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажилладаг.
- Химийн бодис бүрийг ХАЛМ-д заасан нөхцөлд хадгалдаг бөгөөд ихэнх химийн бодисууд нь хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн захиалгаар нийлүүлэгддэг тул манай байгууллагын үйл ажиллагаанд огт хэрэглэгддэггүй. Иймд ургамалын нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл багатай байдаг.


5.4 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЯВЦАД ҮҮСЭЖ БОЛЗОШГҮЙ ОСОЛ, ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

- Бетон нэмэлтийн үйлдвэр, химийн агуулахын цахилгаан монтаж, цахилгаан багаж хэрэгслүүдийг бүрэн бүтэн байдлын шалгалтыг гэрээт Мандах дүүрэн ХХК хамтран зохион байгуулж, шалгалтаар илэрсэн шатсан ослын гэрлүүдийг сольсон.

- Шинээр баригдсан задгай агуулахад гал унтраах хорнуудыг байрлуулсан.
- Ажилчдыг 1 жилийн давтамжтайгаар МУ-ын ХАБЭА-н хууль болон бусад холбогдох дүрэм журмын дагуу эрүүл мэндийн цогц үзлэг шинжилгээнд тогтмол хамруулж, төслийн үйл ажиллагаанаас үүдэлтэй өвчлөлийн тохиолдол байгаа эсэх, хүний эрүүл мэндэд үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн авч хэрэгжүүлэн ажилладаг.
- Химийн бодистой харьцах үеийн зориулалтын хувцас /гутал, резинен бээлий, хамгаалалтын хошуувч г.м/ 2022 оны төсөвт суулгаж бүрэн хангаж ажилсан байна.
- Галын идэвхтэн болон Анхны тусламж үзүүлэгч нарын сургалтыг мэргэжлийн байгууллага нартай хамтран зохион байгуулсан.



Зураг 5. Анхны тусламж үзүүлэх сургалт.



Зураг 6. Цахилгаан багаж хэрэгсэл шалгаж, ослын гэрэл сольсон.

6. НӨХӨН СЭРГЭЭЛТ, ТОХИЖИЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Үйлдвэрийн зам талбай нь зориулалтын хатуу хучилтгүй, ногоон байгууламж багатай байх нь тухайн орчинд ихээхэн тоосжилт үүсгэдэг.

Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-ийн дагуу эзэмшил газрын 10 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу зүлэгжүүлж мод тариалах шаардлагыг үүрэгжүүлж өгсөн байдаг. Иймд эзэмшил газрын 10-аас багагүй хувийг үйлдвэрийн дотоод тохижилт, агаарын бохирдлыг бууруулах, ургамалжуулах зэрэг зорилгоор моджуулах, бут зүлэгжүүлэх арга хэмжээг зайлшгүй хийх шаардлагатай юм.

“МСМ групп” ХХК нь БОННУ-ний 2018-аас 2022 оны 5 жилийн менежментийн төлөвлөгөөнд нь тусгасны дагуу өөрийн эзэмшлийн 40040м² талбайн 10% буюу 4004м²-аас багагүй талбайд ногоон байгууламж байгуулахаар төлөвлөсөн. Энэхүү төлөвлөгөөт ажлыг 5 жилийн хугацаанд шат дараалалтайгаар хэрэгжүүлэхээр ажиллаж байна. 2022 оны байдлаар манай байгууллага нь “Химийн бодисын агуулах болон бетоны нэмэлтийн” үйлдвэрийн барилгын гаднах 900 м² талбайд 2-н төрлийн мод бутыг тарьж, зүлэгжүүлэх ажлыг зохион байгуулсан болно.

№	Арга хэмжээ	Хамрах хүрээ	Тайлбар	Ажлын биелэлт
1	Тарьсан мод бутыг арчлах	Тарьсан мод	5 дугаар сарын эхэн үеэс эхлэн 9 дүгээр сарын дунд үе хүртэл байгууллагын зүлэгжүүлсэн талбайд байнгын усалгаа хийсэн.	100%
2	Талбайн мод бут тарьж зүлэгжүүлэх, орчны тохижилт	Химийн агуулах болон бетоны нэмэлтийн үйлдвэрийн барилгын гаднах талбай	2022 оны 9 сард 900 м ² талбайд 2-н төрлийн 410 мод бут тарих, зүлэгжүүлэх ажлыг амжилттай зохион байгуулсан болно.	100%
3	Мод тарих өдөртэй болох	Нийт ажилчид	Жил бүрийн 05 сарын 14–ний өдөр уламжлал ёсоор Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд 50 ширхэг мод суулгасан.	Жилд 1 удаа



Зураг 7. 2022 оны 9 сард химийн агуулах, бетон нэмэлтийн үйлдвэрийн гадаах тайлбайд мод тарьсан.



Зураг 8. Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд мод тарив. 2020 оны 5 дугаар сарын 14

7. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Тус төслийн үйл ажиллагааны явцад байгалийн унаган байдалд өөрчлөлт оруулахааргүй онц ноцтой бохирдол, хор нөлөө гарахгүй боловч МСМ Групп ХХК 2018 онд Нийгмийн хариуцлагынхаа хүрээнд Нийслэлийн Байгаль Орчны Газартай хамтарсан санамж бичгийн хүрээнд Сэлбэ голын эхэнд Нийслэлийн ногоон бүсэд иргэдэд зориулсан эрүүл агаарт байгалийн төлөв байдлыг хөндөхгүйгээр судалгаа, шинжилгээний ажил явуулах, гэрэл зураг авах, видео бичлэг хийх, явган алхах нөхцлийг бүрдүүлсэн Цохиот хад, Борын рашаан чиглэлийн замыг тохижуулах ажлыг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэн холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгч ашиглалтанд оруулсан болно.

8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Химийн бодисын агуулах нь Хан-Уул дүүргийн 3-р хороонд Яармагийн гүүрнээс зүүн хойш, 3-р цахилгаан станцын урд байрлана. Агуулах байрлах талбайг тус дүүргийн Засаг даргын 2016 оны 04 сарын 26-ний өдрийн А/319 тоот шийдвэрийг үндэслэн олгогдсон 40040 м² талбайг 2 жилийн хугацаатай аж ахуйн авто парк, үйлчилгээний зориулалтаар “МСМ Групп ХХК”-ний охин компани болон “Бетастар” ХХК эзэмшдэг.

Төслийг хэрэгжүүлэх хугацаанд дүүрэг, хороо аж ахуйн нэгж, иргэдийн зүгээс нүүлгэн шилжүүлэх шаардлага болон ямар нэгэн санал гомдол гараагүй учир нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа гараагүй.

9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төслийн үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл үйл ажиллагаагаагаа түр зогсоож энэ тухай сум, дүүргийн засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх ба цаашид Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжыг мөрдөн ажиллах шаардлагатай. “МСМ групп” ХХК-ийн төслийн байршил, онцлогоос хамаараад түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний ажил хийгдээгүй болно.

10. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Химийн бодисын агуулах нь нийт 2112 м² талбайтай, 8000 тн химийн бодис нэг дор хадгалах багтаамжтай ба хадгалж буй химийн бодисыг худалдаалж сэлгэх хүчин чадлаар тооцвол жилд 90000 тн бодис хадгалах хүчин чадалтай.

Үүнд:

- Агуулах нь 2112 м² талбайтай, 1 давхар, зоорийн давхаргүй, газардуулга, аянга зайлуулагч, байгалийн болон зохиомол гэрэлтүүлэг хангалттай, 500

тонны багтаамжтай.

- Хүчинтэй хугацаа бүхий галын дүгнэлттэй.
- Хүн ам оршин суугаа газраас 250-300 м зайд алслагдсан.
- Агуулахын ерөнхий байдлыг зурагт үзүүлэв.



Зураг 9. Агуулахын ерөнхий байдал.

- ✓ Хаалганы хэсэгт налуу босго байгуулан шингэн химийн бодис гадагш алдагдахгүй байх нөхцлийг бүрдүүлсэн, бодис материалын шинж чанараас хамааруулан ангилан хураадаг. Агуулахын зориулалтын тавиур дээр 3 давхарлан байрлуулан хадгалахад аюултай бодисуудыг ангилан хураасан.
- ✓ Тус агуулахад тэсрэмтгий, шатамхай бодис хадгалах тул аюулгүйн зайн хэмжээсийг сайтар баримтлах ёстой бөгөөд тус агуулахын хажууд 2112 м² талбай бүхий ус дамжуулах ган хоолойн усны зэврэлтийг удаашруулагч, ус хөргөлтийн систем дэх нян, бичил биетний хэмжээг тогтворжуулах зориулалтаар хэрэглэгддэг нийт 59 нэр төрлийн, 500 тонн химийн бодис нэг дор хадгалах багтаамжтай ба сард 2000 тонн жилд 24000 тонн бодис хадгалах хүчин чадалтай блок бетонон хана, бетонон шал, хучилтын хавтан зэрэг химийн бодис, галд тэсвэртэй материалаар баригдсан агуулахтай.
- ✓ Агуулахын хана нь төмөр бетон каркас бүхий бетонон ханатай (галд тэсвэртэй), дээвэр нь борооны ус орохооргүй битүүмжлэлтэй байна.

Химийн бодисын хүний эрүүл мэндэд учруулах болзошгүй нөлөөллийг бууруулах чиглэлээр төслийн талбайд ажиллагсад болон ойр орчмын хүн амд химийн бодис дамжин хүрэх эрсдэлээс сэргийлэх дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн:

- Химийн бодистой шууд харьцаж ажилладаг ажиллагсдыг гүйцэтгэж буй ажил үүрэгт нь тохирсон хувийн хамгаалах хэрэгслээр тогтмол хангаж ажилладаг.
- Ажиллагсдад химийн бодистой ажиллах хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны заавар, дүрэм журмыг танилцуулж, химийн бодис үйлдвэрлэгчээс бидэнд ирүүлсэн сургалтын материалын дагуу сургалт явуулдаг.
- Ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны нөхцөлд байнга хяналт

тавьж, осол аваар аюул гарсан тохиолдолд шаардлагатай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр бүрэн хангаж, холбогдох сургалтыг тогтмол явуулдаг.

- Төслийн хэмжээнд өргөн ашигладаг доор дурьдсан нэр төрлийн химийн бодисын осол аюулын тохиолдолд учруулж болзошгүй хор нөлөө, хордлогын шинж, түүнээс урьдчилан сэргийлэх, аюулыг арилгах, саармагжуулах арга, ашиглах хувийн хамгаалах хэрэгсэл, анхны тусламжтай холбоотой арга хэмжээ болон сургалтыг тогтмол явуулдаг.

Гадаа талбайд түр хуурай химийн бүтээгдэхүүн хураан байрлуулдаг талбайг зориулалтын стандартын дагуу задгай агуулах болгосон.



Зураг 10. Хуурай химийн бодисын задгай агуулах.

Химийн бодис тээвэрлэх болон худалдаалах үед гарч болох эрсдэлээс сэргийлэх үүднээс зориулалтын тоног төхөөрөмж ашиглаж байна. Химийн бодисыг

холын замд тээвэрлэхдээ гэрээт тээврийн компани болох АвтоДизель ХХК-ийн зориулалтын стандартын шаардлага хангасан тээврийн хэрэгслүүдээр тээвэрлэлт хийгддэг. Химийн бодисыг тээврийг хэрэгсэлд ачсаны дараа сав багла боодлын бүрэн бүтэн байдал, тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгах хуудсаар шалгах тээвэрт гаргадаг.



Зураг 11. Ачаа ачиж буй байдал. Шалгах хуудас.

Сумбэр Кемикалс ХХК-тай хамтран химийн бодисын хадгалалт, аюулгүй байдлын талаар сургалтыг Бетон нэмэлтийн үйлдвэр, Химийн агуулахын ажилчдын дунд зохион байгуулсан. Мөн Амарвишн ХХК-тай хамтар галын дохиолол болон автомат гал унтраах системийн ажиллагааны талаарх дадлага сургалтыг харуул хамгаалалтын болон химийн хэлтсийн ажилчдын дунд зохион байгуулсан.



Зураг 12. Химийн бодистой харьцах сургалтанд сууж буй байдал, сертификат.



Зураг 13. Автомат гал унтраах системийн дадлага сургалт.

11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Химийн бодисын агуулахын үйл ажиллагаанаас ахуйн болон үйлдвэрийн хатуу хог хаягдал гарна.

Хог хаягдлыг лонх, лааз, цаас хоолны үлдэгдэл, бусад гэсэн байдлаар нь ангилан хадгалж дахин ашиглагдах хэсгийг нь хоёрдогч түүхий эдийн цэгт нийлүүлэн, үлдэх буюу ашиглагдахгүй хэсгийг хогийн цэг рүү ачуулдаг.



Зураг 14. Ангилан хаягдаг хогийн савнууд.

11.1 ХОГ ХАЯГДАЛ, ХИМИЙН ХОРТОЙ БОДИСЫГ УСТГАХ

- Химийн бодисын үлдэгдэл, хаягдал, хаяг нь мэдэгдэхгүй болсон бодис, хугацаа дууссан болон ашиглалтаас гарсан гэх зэрэг олон шалтгаанаас үүдэн тэдгээрт устгал хийх шаардлагатай болсон тохиолдолд уг асуудлыг хариуцсан төр захиргааны байгууллагаас зохих зөвшөөрөл болон зааварчилгааг авч хамтран ажиллах болно.
- Химийн бодис алдагдсан тохиолдолд агуулахын зориулалтын зумпэнд урсган, уг химийн бодисыг тухайн бодисын асгарах алдагдах тохиолдолд авах арга хэмжээний дагуу инерт материалд шингээн саармагжуулан зааврын дагуу устгах.
- Химийн бодисын хаягдал устгасан тухай нотломжийг дэлгэрэнгүй бичиж, устгал хийхэд оролцсон хүмүүс гарын үсэг зурж баталгаажуулна.
- Химийн бодис ашиглагч нь технологийн горимыг нарийн чанд баримтлан ажиллаж, орчиндоо болон ажлын байранд зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн хог хаягдал гаргахгүй байх үүрэг хүлээх ба гаргасан тохиолдолд түүнийг бууруулах, саармагжуулах, байгаль орчинд халгүй аргаар устгах арга хэмжээг өөрийн хөрөнгөөр авч хэрэгжүүлэн ажиллана.
- Химийн бодисын сав, боодлыг ахуйн зориулалтаар ашиглахыг хориглоно.
- Хогийг бөөгнүүлэн хаях бөгөөд хогийг анхааруулах тэмдэг бүхий доор нь хатуу хучилт хийсэн хогийн цэгт цуглуулж, зөвшөөрөгдсөн цэгт хүргүүлэн устгал хийлгэж байх.

Манай байгууллага нь Эко орчин ХХК”-тай А-22/010 тоот гэрээг хийж, хог хаягдлыг ачиж, тээвэрлэх ажлыг хамтран зохион байгуулан ажиллаж байна. /гэрээг хавсаргав/ уг гэрээгээр Эко орчин ХХК-ийн ажилчид тусгай хог хаягдал тээвэрлэх зориулалтын машинаар хог хаягдлыг цагийн хуваарийн дагуу ирж аван тусгай хог хаягдлын цэгт тушаан устгадаг.

Машин техникээс гарах шингэн тос тосолгооны хаягдлыг тусгай зориулалтын хатуу хучилттай талбайд битүү зориулалтын саванд хуримтлуулан хадгалдаг бөгөөд байгаль орчны яам болон холбогдох төрийн захиргааны төв байгууллагын үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл бүхий хаягдал тосыг байгальд ээлтэй технологиор “NI BI OIL” ХХК-нд тушааж дахин боловсруулдаг.

Химийн бодисын хаягдал, үлдэгдэл гарсан тохиолдолд үйлдвэрийн хаягдал материал устгах мэргэжлийн байгууллагад хандаж устгуулахаар “Цэцүүх Трейд ХХК”-тай гэрээ байгуулан хамтарч ажиллаж эхэлсэн.
/гэрээг хавсаргав/

МСМ Групп ХХК нь хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах ажлыг зохион байгуулдаг бөгөөд дахин ашиглах боломжтой хог хаягдлыг тусгай хогийн саванд цуглуулж, хоёрдогч түүхий эд худалдан авах цэгт тушаадаг.

Хаягдал хуванцар савыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагын үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл бүхий “MOG PLASTIC” ХХК-нд нийлүүлж байгаль экологид ээлтэйгээр дахин боловсруулдаг.



Зураг 15. Хуурай хог хаягдал түр хадгалах цэг.

12. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
1	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31.6-д заасны дагуу Экологийн паспорт хөтлөх. MNS.4219:1994 Байгаль орчны хамгаалал. Аж ахуй нэгжийн экологийн паспорт.	2022	“МСМ групп” ХХК	ISO14001:2015 стандартыг ОШМИ Групптай хамтран 2022 оны 10 сард хэрэгжүүлж эхэлсэн ба стандартын бичиг баримттай уялдах тул MNS.4219:1994 Байгаль орчны хамгаалал. Аж ахуй нэгжийн экологийн паспортыг стандарт хэрэгжүүлэх хугацаанд хийж гүйцэтгэж байна.
2	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах	2022	“МСМ групп” ХХК	2022 оны 11 сард багтаан боловсруулж батлуулах
3	Тухайн жилийн байгаль орчны менежментийн биелэлтийн тайланг боловсруулж дүгнүүлэх	2022	“МСМ групп” ХХК	2022 оны 10 сард биелэлтийн тайланг боловсруулж тайлагнах.

13. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн хүрээнд Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг мэргэжлийн баталгаажуулсан лаборатортай дараах Ногоон Титэм ХХК, Хан Лаб ХХК, Инженер Геодези ХХК, Монгол-Ус ТӨҮГ байгууллагуудтай хамтран агаар, хөрсний шинжилгээг 2 удаа, усны шинжилгээг 1 удаа хийж дараах үр дүнгүүдийг гаргалаа.

- 2022 оны БОМТөлөвлөгөөнд тусгагдсаны дагуу үйл ажиллагааг хэвийн явуулж байна.
- Бид 2022 оны ОХШХ-ний хөтөлбөрийг биелэлтийг хангах зорилгоор агуулах орчмоос хөрсний дээж авч хөрсний механик бүрэлдэхүүн, хөрсний химийн задлан шинжилгээ, хөрсний хүнд металлын агууламж болон хөрсний эрүүл ахуйг эрх бүхий итгэмжлэгдсэн лабораториор тодорхойлуулсан. Агаарын чанарын хяналт шинжилгээнд агуулахын гадна 1 цэг, агуулахын дотор 1 цэг, бетон нэмэлтийн үйлдвэр дотор 1 цэг, агаарын чанарын 3 цэгээс дээж авч шинжлүүлсэн.
- Ундны усан дахь эмгэг төрүүлэгч бактерийн тоо, ундны усны бүрэн шинжилгээ, ундны усан дахь хүнд металлын агууламж жилд нэг удаа үзсэн ямар нэгэн нян илрээгүй, стандартаас давсан үзүүлэлт гараагүй болно.
- Агаарын чанарын түгээмэл бохирдуулагч болох хүхэрлэг хий (SO_2), азотын давхар исэл (NO_2) агаар дахь $PM_{2.5}$ тоосонцорын хэмжилтийг Агаарын чанарын стандарт MNS4585:2016 болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага MNS4990:2015 стандарттай харьцуулахад хэвийн хэмжээнд байна. $PM_{2.5}$ тоосонцорын хэмжээ нь стандартаас илүү гарсан. Нарийн ширхэгтэй тоосонцор илүү гарсан гол шалтгаан нь 3-р цахилгаан станцын нүүрсний овоолго байралдаг ба нүүрсний нарийн ширхэгтэй тоосонцор маш их байгаас $PM_{2.5}$ тоосонцор хэмжилт өндөр гарсан.
- Хөрсний шинжилгээний үр дүнд MSM групп ХХК-ний талбайн хөрсөн дэх хар тугалга, кадми, никкел зэрэг элементүүд Монгол улсын стандартын (MNS 5850:2008) хүлцэх агууламжын хэмжээнээс даваагүй буюу бохирдолгүй байна. Харин хүнцэлийн агууламж хүлцэх агууламжаас хэтэрсэн байна. Тухайн гадарга, хөрс нь харьцангуй нимгэн, суурь чулуулаг нь гадарга дээр гарсанаас чулуулагтай холбоотой байгалийн хөрсний аномаль хэмжээ нь өндөр гарсан байх магадлалтай. Ерөнхийдөө Монгол орны хэмжээнд ихэнхдээ өндөр гардаг учир хүнцэлээр бохирдсон гэж үзэх боломжгүй юм.



Зураг 16. Төслийн талбайн харагдах байдал.


13.1 ХӨРСНИЙ ЭЛЭГДЭЛ, ЭВДРЭЛ

2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ОХШХ-ийн хүрээнд хөрсөн бүрхэвчийг эрүүл ахуй, бохирдлын байдлыг дээж авч итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүллээ.

Хөрсний дээж авах цэгийг сонгохдоо 2022 оны БОМТ-ний ОХШХ-т тусгасаны дагуу дараах 2 цэгийг сонгож авсан. Үүнд:

№	Дээж авсан байршил	Координат
1	Ачаа буулгах тавцан	47°53'34.81"N 106°52'9.50"E
2	Хуучин хогийн цэг	47°53'31.61"N 106°52'4.77"E

Химийн бодисын агуулах орчим: Агуулах орчмын хөрс нь бага зэргийн элэгдэл, эвдрэлд өртсөн, нийт хөрсөн бүрхэвчийн 70-80%-д барилга, байгууламж болон зам талбай эзэлж байна.



Зураг 17. Хөрсний дээж авсан цэгүүдийн байршил.

Арга зүй

Хээрийн судалгаа: Хөрсний гадаргын төлөв байдал, хөрсний үржил шимийн түвшин, хөрсний хими, физик шинж чанар, эрүүл ахуй бохирдолыг тодорхойлох зорилгоор жилд 2 удаа 2 цэгт ухалт хийж, өнгөн хөрсний хөрсний нэг цэгээс 3, нийт 2 удаагийн 12 дээж авсан. Талбайн хэмжээ, нөлөөлөлд өртсөн байдлыг харгалзан үзэж дээж авах цэгийг тодорхойлсон.



Зураг 18. Ачаа буулгах тавцангийн хажуугаас хөрсний дээж авч байна.



Зураг 19. Хуучин хогийн цэг.



Зураг 20. Хуучин хогийн цэг.

2022 оны 6 сарын 17-ны хөрсний дээжийн хариунууд



ХАНЛАБ ХХК
Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 17 р хороо, Богд Жавзандамба
гудамж 34/6 тоот, Хан Рашаан компанийн байр
Утас: 70109968, 99995316
<http://www.khanlab.mn>



ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

ЗАХИАЛГА №: МБ 2022/145-2

ДЭЭЖИЙН ТӨРӨЛ,
ТОО:

Хөрс, 1

ЗАХИАЛАГЧИЙН НЭР: НОГООН ТИТЭМ ХХК

ДЭЭЖИЙН ДУГААР: Ачих тавцангийн хажууд

ЛАБОРАТОРИЙН ДУГААР: Л-468

ДЭЭЖИЙН ХЭМЖЭЭ, г: 420

№	ҮЗҮҮЛЭЛТ	СТАНДАРТ АРГА	НЭГЖ	ЗӨВШӨӨРӨГДӨХ ДЭЭД ХЭМЖЭЭ MNS 3297:1991	ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН
1	Бактерийн ерөнхий тоо	MNS 6341:2012	1 г-д	-	$1.8 \cdot 10^5$
2	Колиформ гэдэсний бүлгийн нянгийн таныц	MNS 5367:2004	1 г-д	илрэхгүй	илрээгүй
3	Халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн нянгийн таныц	MNS 5367:2005	1г-д	илрэхгүй	илрээгүй
4	Клостридиум перфрингенсийн таныц	MNS 6341:2012	1 г-д	илрэхгүй	илрэв (0.01)
5	Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян	MNS 6341:2012	25 г-д	илрэхгүй	илрээгүй

Дэд захирал

С.Туул, PhD

Сорилтын үр дүн зөвхөн тухайн дээжинд хамаарна.
Дээжлэлийн талаарх асуудлыг манай лаборатори хариуцахгүй болно.

ХҮЛЭЭН АВСАН ОГНОО: 2022.06.21

ДЭЭЖ БОЛОВСРУУЛАЛТ: хийгдсэн.

ШИНЖИЛГЭЭ ЭХЭЛСЭН ОГНОО: 2022.06.21

ХУУДАСНЫ ТОО: 1

ШИНЖИЛГЭЭ ДУУССАН ОГНОО: 2022.06.29

Хамтран ажилласан танд талархлаа.

Хуудас 1-1



ХАНЛАБ ХХК
Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 17 р хороо, Бөгд Жавзандамба
гудамж 34/6 тоот, Хан Рашаан компанийн байр
Утас: 70109968, 99995316
<http://www.khanlab.mn>



ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

ЗАХИАЛГА №: МБ 2022/145-1

ДЭЭЖИЙН ТӨРӨЛ,
ТОО:

Хөрс, 1

ЗАХИАЛАГЧИЙН НЭР: НОГООН ТИТЭМ ХХК

ДЭЭЖИЙН ДУГААР: Хуучин хогийн цэг

ЛАБОРАТОРИЙН ДУГААР: Л-467

ДЭЭЖИЙН ХЭМЖЭЭ, г: 450

№	ҮЗҮҮЛЭЛТ	СТАНДАРТ АРГА	НЭГЖ	ЗӨВШӨӨРӨГДӨХ ДЭЭД ХЭМЖЭЭ MNS 3297:1991	ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН
1	Бактерийн ерөнхий тоо	MNS 6341:2012	1 г-д	-	$1.5 \cdot 10^5$
2	Колиформ гэдэсний бүлгийн нянгийн таныц	MNS 5367:2004	1 г-д	илрэхгүй	илрээгүй
3	Халуунд гэсвэртэй гэдэсний бүлгийн нянгийн таныц	MNS 5367:2005	1г-д	илрэхгүй	илрээгүй
4	Клостридиум перфрингенсийн таныц	MNS 6341:2012	1 г-д	илрэхгүй	илрэв (0.1)
5	Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян	MNS 6341:2012	25 г-д	илрэхгүй	илрээгүй

Дэд захирал

С.Туул, PhD

Сорилгогч үр дүн зөвхөн тухайн дээжинд хамаарна.
Дээжлэлтийн талаарх асуудлыг манай лаборатори хариуцахгүй болно.

ХҮЛЭЭН АВСАН ОГНОО: 2022.06.21

ДЭЭЖ БОЛОВСРУУЛАЛТ: хийгдсэн.

ШИНЖИЛГЭЭ ЭХЭЛСЭН ОГНОО: 2022.06.21

ХУУДАСНЫ ТОО: 1

ШИНЖИЛГЭЭ ДУУССАН ОГНОО: 2022.06.29

Хамтран ажилласан танд талархлаа.

Хуудас 1-1



**ХӨРС СУДЛАЛЫН
ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ**



Дугаар: 22/2490

ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ ХХК
Утас/Факс 77278899, 77288899
E-mail: soil_lab@geo-mongol.mn

Дээж авсан огноо: 2022 он 06 сарын 20

Шинжилгээ хийсэн огноо: 2022 он 06 сарын 21-22

Дээж авсан газрын нэр: Улаанбаатар хот, ХУД, 4-р хороо, “Эм Эс Эм” ХХК, үйлдвэрийн байр

Координат: -

Дээж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: “Ногоон титэм” ХХК

Харилцах утас: 88088918, 88062879

Хөрсний химийн задлан шинжилгээний дүн

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	pH	Давс, %	ЦДЧ, dsm	Ялзмаг, %	CaCO ₂ , %	Шингээгдсэн сууриуд мг-экв/100 гр		Шим тэжээлийн элементүүд мг/100 гр	
									Ca	Mg	P ₂ O ₅	K ₂ O
0	1	2	3	4	5	6	7	8	10	11	12	13
1	22/5249	Х/Хогын цэг	-	8.80	0.03	0.068	0.75	0.16	6.5	1.7	1.7	4
2	22/5250	АТ хажууд	-	8.92	0.28	0.576	1.02	2.88	8.9	5.6	2.3	10

Хөрсний механик бүрэлдэхүүн

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	Механик ширхэгүүд %, ширхэгийн хэмжээ, мм						
				1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
1	22/5249	Х/Хогын цэг	-	59.5	19.9	9.0	2.3	6.5	2.7	11.5
2	22/5250	АТ хажууд	-	37.6	32.9	12.7	5.8	6.6	4.4	16.8

Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжэнд хамаарах ба хуулбарлан хэрэглэхийг хориглоно.

Шинжилгээ хийсэн арга стандарт:

(MNS 3310:1991, MNS ISO 10390:2001, MNS 6824:2020)

Лабораторийн эрхлэгч:

Л. Цагаандархи /MS.c/

Задлан шинжээч:

Х.Жаргалмаа



**ХӨРС СУДЛАЛЫН
ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ**



Дугаар: 22/2491

ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ ХХК
Утас/Факс 77278899, 77288899
E-mail: soil_lab@geo-mongol.mn

Дээж авсан огноо: 2022 он 06 сарын 20

Шинжилгээ хийсэн огноо: 2022 он 06 сарын 21-22

Дээж авсан газрын нэр: Улаанбаатар хот, ХУД, 4-р хороо, “Эм Эс Эм” ХХК, үйлдвэрийн байр

Координат: -

Дээж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: “Ногоон титэм” ХХК

Харилцах утас: 88088918, 88062879

Хөрсний хүнд металл

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	Хүнд металл мг/кг					
				Ni /Никель/	Cd /Кадми/	Pb /Хар тугалга/	Cu /Зэс/	Zn /Цайр/	Cr /Хром/
1	22/5251	Х/Хогын цэг	-	13.2	ND	ND	ND	30.9	ND
2	22/5252	АТ хажууд	-	15.1	ND	9.83	3.65	28.0	ND
Хүлцэх агууламж /MNS 5850:2019/				150,0	3,0	100,0	100,0	300,0	150,0
Хортой агууламж /MNS 5850:2019/				1000,0	10,0	500,0	500,0	600,0	400,0
Аюултай агууламж /MNS 5850:2019/				1800,0	20,0	1200,0	1000,0	1000,0	1500,0
Элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт				/MNS 5850:2019/					

***ND-not detect**

Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжинд хамаарах ба хуулбарлан хэрэглэхийг хориглоно.

Шинжилгээ хийсэн арга стандарт:

(MNS ISO 11466:2007)

Лабораторийн эрхлэгч:

Л. Цагаандархи /MS.c/

Задлан шинжээч:

Х.Жаргалмаа



2022 оны 10 сарын 05-ны хөрсний дээжийн хариунууд



ХАНЛАБ ХХК
Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 17 р хороо, Богд Жавзандамба
гудамж 34/6 тоот, Хан Рацан компанийн байр
Утас: 70109968, 99995316
<http://www.khanlab.mn>



ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

ЗАХИАЛГА №: МБ 2022/289-2

ДЭЭЖИЙН ТӨРӨЛ,
ТОО:

Хөрс, 1

ЗАХИАЛАГЧИЙН НЭР: М ЭС ЭМ ХХК

ДЭЭЖИЙН ДУГААР: Хуучин хогын цэг

ЛАБОРАТОРИЙН ДУГААР: Л-866

ДЭЭЖИЙН ХЭМЖЭЭ, г: 200

№	ҮЗҮҮЛЭЛТ	СТАНДАРТ АРГА	НЭГЖ	ЗӨВШӨӨРӨГДӨХ ДЭЭД ХЭМЖЭЭ MNS 3297:1991	ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН
1	Бактерийн ерөнхий тоо	MNS 6341:2012	1 г-д	-	$9.5 \cdot 10^4$
2	Колиформ гэдэсний бүлгийн нянгийн таныц	MNS 5367:2004	1 г-д	илрэхгүй	илрэв (0.1)
3	Халуунд гэвэртэй гэдэсний бүлгийн нянгийн таныц	MNS 5367:2005	1г-д	илрэхгүй	илрээгүй
4	Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян	MNS 6341:2012	25 г-д	илрэхгүй	илрээгүй
5	Клоостридиум перфригивенсийн таныц	MNS 6341:2012	1 г-д	илрэхгүй	илрэв (0.01)

Чанарын менежер Д.Пүрэвжаргал

Сорилтын үр дүн зөвхөн тухайн дээжинд хамаарна.
Дээжлэлийн талаарх асуудлыг манай лаборатори хариуцахгүй болно.

ХҮЛЭЭН АВСАН ОГНОО: 2022.10.06

ДЭЭЖ БОЛОВСРУУЛАЛТ: хийгдсэн.

ШИНЖИЛГЭЭ ЭХЭЛСЭН ОГНОО: 2022.10.06

ХУУДАСНЫ ТОО: 1

ШИНЖИЛГЭЭ ДУУССАН ОГНОО: 2022.10.11

Хамтран ажилласан танд талархлаа.

Хуудас 2-2



ХАНЛАБ ХХК
Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 17 р хороо, Богд Жавзандамба
гудамж 34/6 тоот, Хан Рашаан компанийн байр
Утас: 70109968, 99995316
<http://www.khanlab.mn>



ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

ЗАХИАЛГА №: МБ 2022/289-1

ДЭЭЖИЙН ТӨРӨЛ,
ТОО:

Хөрс, 1

ЗАХИАЛАГЧИЙН НЭР: М ЭС ЭМ ХХК

ДЭЭЖИЙН ДУГААР: Ачилтын тавцан

ЛАБОРАТОРИЙН ДУГААР: Л-865

ДЭЭЖИЙН ХЭМЖЭЭ, г: 200

№	ҮЗҮҮЛЭЛТ	СТАНДАРТ АРГА	НЭГЖ	ЗӨВШӨӨРӨГДӨХ ДЭЭД ХЭМЖЭЭ MNS 3297:1991	ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН
1	Бактерийн ерөнхий тоо	MNS 6341:2012	1 г-д	-	$1.5 \cdot 10^5$
2	Колиформ гэдэсний бүлгийн нянгийн таныц	MNS 5367:2004	1 г-д	илрэхгүй	илрэв (0.01)
3	Халуунд гэсвэртэй гэдэсний бүлгийн нянгийн таныц	MNS 5367:2005	1 г-д	илрэхгүй	илрээгүй
4	Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян	MNS 6341:2012	25 г-д	илрэхгүй	илрээгүй
5	Клостридиум перфрингенсийн таныц	MNS 6341:2012	1 г-д	илрэхгүй	илрэв (0.001)

Чанарын менежер

Д.Пүрэвжаргал

Сорилтын үр дүнд зөвхөн тухайн дээжэнд хавсарна.
Дээжлэлтийн тасварт агууламшаар лаборатори хариуцахгүй болно.

ХҮЛЭЭН АВСАН ОГНОО: 2022.10.06

ДЭЭЖ БОЛОВСРУУЛАЛТ: хийгдсэн.


ШИНЖИЛГЭЭ ЭХЭЛСЭН ОГНОО: 2022.10.06

ХУУДАСНЫ ТОО: 1

ШИНЖИЛГЭЭ ДУУССАН ОГНОО: 2022.10.11

Хамтран ажилласан танд талархлаа.

Хуудас 2-2



**ХӨРС СУДЛАЛЫН
ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ**



ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ ХХК

Утас/Факс 77278899, 77288899

E-mail: soil_lab@geo-mongol.mn

Дугаар: 22/3692

Дээж авсан огноо: 2022 он 10 сарын 06

Шинжилгээ хийсэн огноо: 2022 он 10 сарын 07-09

Дээж авсан газрын нэр: Улаанбаатар хот, ХУД, 3-р хороо

Координат: -

Дээж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: “М-Эс-Эм” ХХК

Харилцах утас: 88088918

Хөрсний химийн задлан шинжилгээний дүн

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	pH	Давс, %	ЦДЧ, dsm	Ялзмаг, %	CaCO ₂ , %	Шингээгдсэн сууриуд мг-экв/100 гр		Шим тэжээлийн элементүүд мг/100 гр	
									Ca	Mg	P ₂ O ₅	K ₂ O
0	1	2	3	4	5	6	7	8	10	11	12	13
1	22/8279	Ачилтын тавцан	-	8.30	0.2	0.440	7.11	0.16	18.3	6.9	2.6	26
2	22/8280	Хуучин хогийн цэг	-	8.02	1.12	2.490	1.21	0.16	9.2	4.3	2.2	9

Хөрсний механик бүрэлдэхүүн

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	Механик ширхэгүүд %, ширхэгийн хэмжээ, мм						
				1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
1	22/8279	Ачилтын тавцан	-	31.5	36.7	17.0	2.3	6.9	5.5	14.7
2	22/8280	Хуучин хогийн цэг	-	27.1	40.5	15.4	1.0	6.7	9.4	17.0

Жич: Энэхүү шинжилгээний харцу нь тухайн цэгийн дээжилд хамаарах ба хуулбарлан хэрэглэхийг хориглоно.

Шинжилгээ хийсэн арга стандарт:

(MNS 3310:1991, MNS ISO 10390:2001, MNS 6824:2020)

Лабораторын эрхлэгч:

Л.Цагаандархи /MS.c/

Задлан шинжээч:

Х.Жаргалмаа



“МСМ ГРУПП” ХХК-ИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНД ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ “ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ” ТӨСЛИЙН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



ХАНЛАБ ХХК
Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 17-р хороо, Богд Жавзандамба
гудамж 34/6 тоот, Хан Рашаан компанийн байр
Утас: 70109968, 99995316
<http://www.khanlab.mn>



ИНГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

ЗАХИАЛГА №: 2022/1908

ЗАХИАЛАГЧИЙН НЭР: **MSM LLC**

ДЭЭЖИЙН ТӨРӨЛ, ТОО: **Хөрс, 2**

№	ЛАБОРАТОРИЙН ДУГААР	ДЭЭЖИЙН ДУГААР	ДЭЭЖИЙН ТОДОРХОЙЛОЛТ	ЭЛЕМЕНТ, %					ЭЛЕМЕНТ, мг/кг				
				Na	Ca	Mg	K	Fe _{инйт}	As	Ba*	Be	Bi	Cd
1	Л-20441	Ачилтын тавцан /2022.10.05/	Хөрс	2.01	1.37	0.35	2.33	1.90	9.24	588.5	<5.0	<10.0	<1.0
2	Л-20442	Хуучин хөгийн цэг /2022.10.05/	Хөрс	2.33	0.98	0.29	2.50	1.76	9.28	509.5	<5.0	<10.0	<1.0
MNS5850:2019				-	-	-	-	-	20.00	-	-	-	3.00

№	ЛАБОРАТОРИЙН ДУГААР	ДЭЭЖИЙН ДУГААР	ДЭЭЖИЙН ТОДОРХОЙЛОЛТ	ЭЛЕМЕНТ, мг/кг									
				Co	Cr	Cu	La	Li	Mn	Mo	Ni	P	Pb
1	Л-20441	Ачилтын тавцан /2022.10.05/	Хөрс	8.42	24.15	22.21	12.93	20.12	479.3	<5.0	15.34	446.3	21.01
2	Л-20442	Хуучин хөгийн цэг /2022.10.05/	Хөрс	8.24	20.78	9.78	10.01	19.26	414.6	<5.0	10.98	431.0	20.22
MNS5850:2019				50.00	150.0	100.0	-	-	-	5.0	150.0	-	100.0

№	ЛАБОРАТОРИЙН ДУГААР	ДЭЭЖИЙН ДУГААР	ДЭЭЖИЙН ТОДОРХОЙЛОЛТ	ЭЛЕМЕНТ, мг/кг							
				Sb	Se	Sr*	Ti	V	Y	Zn	Zr*
1	Л-20441	Ачилтын тавцан /2022.10.05/	Хөрс	<10.0	<5.0	284.2	1947	37.40	10.23	71.36	48.15
2	Л-20442	Хуучин хөгийн цэг /2022.10.05/	Хөрс	<10.0	<5.0	232.0	2177	39.38	8.84	44.57	49.65
MNS5850:2019				-	10.00	800.0	-	150.0	-	300.0	-

Чанарын менежер: **Д. Пүрэвжаргал**

Тайлбар: * Бүрэн задрахгүй. /Хагас тоон утга/

Шинжилгээнд өргүүлсэн дээжийг 1 сар хүртэл хугацаагаар хадгална.

Сорилтын үр дүн зөвхөн гухайн дээжинд хамаарна. Дээжлэлтийн талаарх асуудлыг манай лаборатори хариуцахгүй болно.

ХҮЛЭЭН АВСАН ОГНОО: **2022.10.06**

ДЭЭЖ БОЛОВСРУУЛАЛТ: **хийгдээгүй**

ШИНЖИЛСЭН ОГНОО: **2022.10.18**

ХУУДАСНЫ ТОО: **1**

Хамтран ажилласан танд талархлаа.


Хуудас 1-1

13.2 АГААР

2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ОХШХ-ийн хүрээнд агаарын чанарын бохирдлын байдлыг дээж авч итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлээ.

Агаарын дээж авах цэгийг сонгохдоо 2022 оны БОМТ-ний ОХШХ-т тусгасаны дагуу дараах 3 цэгийг сонгож авсан. Үүнд:

№	Дээж авсан байршил	Координат
1	Бетон нэмэлтийн үйлдвэр	47°53'33.31"N 106°52'10.17"E
2	Химийн бодисын агуулах	47°53'34.09"N 106°52'11.49"E
3	Ачаа буулгах тавцан	47°53'34.91"N 106°52'10.08"E




Зураг 21. Агаарын дээж авсан цэгүүдийн байршил.

“Ногоон Титэм” ХХК нь 2022 оны 6 сард, 10 сард “MSM Групп” ХХК-ний талбайд агаарын чанарын хяналт шинжилгээний 3 цэгт агаарын чанарын түгээмэл бохирдуулагч болох хүхэрлэг хий (SO_2), азотын давхар исэл (NO_2) агаар дахь $PM_{2.5}$ буюу нарийн тоосонцорын хэмжилтийг хийв. Агаарын чанарын хэмжилтийг DUSTRAK8530 багажаар 120 минутын хугацаатай хэмжиж Агаарын чанарын стандарт MNS4585:2016 болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага MNS 4990:2015 болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд.Шуугианы норм. Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS 5002:2000 стандарттай харьцуулан үнэлэлт дүгнэлт өгсөн.



Зураг 22. Агаарын цэг-1. /Бетон нэмэлтийн үйлдвэр дотор/



Зураг 23. Агаарын цэг-2. /Химийн бодисын агуулах дотор/



Зураг 24. Агаарын цэг-3. /Ачаа буулгах тавцан Химийн агуулахын гадна/

Агаар бохирдуулагч эх үүсвэрүүдээс ялгарч буй хаягдал дахь хортой хийнүүд нь орчны агаарын чанарт шууд нөлөөлөхөөс гадна агаар мандал дахь физик, химийн процессуудын үр дүнд илүү хоруу чанартай химийн нэгдлүүд, нарийн ширхэглэлтэй тоосонцрыг үүсгэж байдаг. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Олон улсын байгаль орчин, эрүүл мэндийн судалгааны төвүүдээс хүрээлэн буй орчны агаар дахь тоосонцрыг хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөлд үндэслэн тогтоосон зөвшөөрөгдөх агууламжын хэмжээнд хянаж байхыг зөвлөсөн байдаг.

PM2.5 тоос: PM2.5 нарийн тоосонцорын хэмжээ нь стандартаас илүү гарсан. Нарийн ширхэгтэй тоосонцор илүү гарсан гол шалтгаан нь манай байгууллагын хажууд 3-р дулааны цахилгаан станцын нүүрсний овоолго байралдаг ба нүүрсний нарийн ширхэгтэй тоосонцор маш их байгаас PM2.5 тоосонцор хэмжилт өндөр гарсан.

PM2.5 тоосонцор лабораторийн хариу

2022 оны 06 сарын 17-ны агаарын дээжийн хариунууд



ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ТАЙЛАН

Үйлчлүүлэгч: “Эм Эс Эм” ХХК

Дугаар. REP-2206117

Эрүүл ахуй, хор судлалын лаборатори

Хэлт энд Сэфти Солушинс ХХК, Улаанбаатар хот 13374, БЗД, 25-р хороо, Манлайбаатар
Дамидансүрэнгийн гудамж, УБ Тауэр барилга 705 тоот
Тел: +976-7577-9922; +976-9400-4884, Имэйл: contact@hss.mn, Вэб: hss.mn



5. Сорилтын үр дүн						
PM2.5 тоосонцор						
#	Сорьцны дугаар	Сор.агаарын эзлэхүүн, м ³	Сорьц цуглуулсан байршил	PM2.5 тоосонцорын жин, мг/фильтер	PM2.5 тоосонцорын концентраци, мг/ м ³	PM2.5 тоосонцорын концентраци, мкг/ м ³
1.	2204614	0.402	Химийн агуулах	0.03	0.08	82.17
2.	2204615	0.360	Үйлдвэрийн агуулахын гадна	0.34	0.96	956.51
3.	22061083	0.360	Бетон нэмэлтийн үйлдвэр	0.07	0.19	186.30

2022 оны 10 сарын 05-ны агаарын дээжийн хариунууд



ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ТАЙЛАН

Үйлчлүүлэгч: “М Эс Эм ” ХХК

Дугаар. REP-2210203

Эрүүл ахуй, хор судлалын лаборатори

Хэлт энд Сэфти Солушинс ХХК, Улаанбаатар хот 13374, БЗД, 25-р хороо,
Манлайбаатар Дамидансүрэнгийн гудамж, УБ Тауэр барилга 705 тоот
Тел: +976-7577-9922; +976-9400-4884, Имэйл: contact@hss.mn, Вэб: hss.mn



5. Сорилтын үр дүн						
PM2.5 тоосонцор						
#	Сорьцны дугаар	Сор.агаарын эзлэхүүн, м ³	Сорьц цуглуулсан байршил	PM2.5 тоосонцорын жин, мг/фильтер	PM2.5 тоосонцорын концентраци, мг/ м ³	PM2.5 тоосонцорын концентраци, мкг/ м ³
1.	22092403	0.366	Ачилтын хэсэг	0.07	0.19	188.64
2.	22092405	0.375	Агуулах	0.12	0.31	309.46
3.	22092407	0.363	Бетон нэмэлтийн үйлдвэр	0.10	0.26	264.64

Азотын давхар исэл (NO₂)

Өнгөгүй, бага зэрэг таагүй үнэртэй хий бөгөөд агаар мандалд их агууламжтай байх үед бор шаргал, улаан хүрэн өнгөтэй болж, урвалд идэвхитэй ордог. Агаарын бохирдлын эх үүсвэрээс ялгарсан азотын исэл (NO₂) агаар дахь хүчилтөрөгчтэй нэгдэхэд үүснэ. Үүссэн азотын давхар исэл нь агаар дахь дэгдэмхий органик нэгдэл зэрэг хүчтэй исэлдүүлэгчийг үүсгэнэ. Аливаа түлшний өндөр температурт шатах үед үүсдэг ба автотээврийн хэрэгслийн дотоод шаталт, цахилгаан халаагуур, цахилгаан станц, химийн үйлдвэр, хог шатаах зуух зэрэг агаар бохирдуулах эх үүсвэрээс ялгардаг.

Хүхэрлэг хий (SO₂)

Хүхэрлэг хий /SO₂/ нь хүхэр агуулсан түлшний шаталтаас үүсэх бөгөөд орчныг бохирдуулагч хортой хий. Хүхэрлэг хий нь нүүрс ашигладаг дулааны цахилгаан станц, үйлдвэр, металлург, гангийн үйлдвэр, нүүрс шатаадаг ахуйн зуух, тээврийн хэрэгслийн түлшний шаталтаас үүснэ. Хүхэрлэг хийний хоруу чанар нь өндөр концентрацитай үед амьсгал давчдах, хоолой хорсох гэх мэт шинж тэмдэг илэрдэг бөгөөд амьсгалын замын эрхтэний системийг гэмтээдэг. $SO_2 + H_2O + O_2 \rightarrow H_2SO_4$ урвалаар томоохон хот, үйлдвэрийн бүсэд хүхэрлэг хийн өндөр концентраци нь усны ууртай нэгдэж хүчиллэг тундас (H₂SO₄) үүсгэдэг. Энэ химийн нэгдэл нь маш хүчиллэг шинжтэй бөгөөд агаарт дэгдэж борооны устай хамт газар буудаг. Хүний эрүүл мэндэд ялангуяа арьс, үсэнд хортой. Барилга байгууламжийг аажмаар элэгдүүлдэг.

2022 оны 06 сарын 17-ны агаарын дээжийн хариунууд

6/30/22, 4:54 PM

Green-Crown LIMS v1.0

НОГООН ТИТЭМ ХХК-н захирлын
2020 оны 12 сарын 25-ний өдрийн
2020/2-1 дугаар тушаалын хавсралт



НОГООН ТИТЭМ ХХК
Хан-Уул дүүрэг, 3-р хороо,
Сан-Констракин ХХК байр, 222 тоот.
Утас: 70005432



ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ТАЙЛАН
TEST REPORT OF LABORATORY

Ажлын дугаар /Registration number/: 220615

Сорилтын төрөл /The type of test/: Агаар Air

Захиалагчийн мэдээлэл: МСМ групп

/The name of customer's request for analysis/

Түүвэр дээжийн мэдээлэл /Sample details/: ЭмЭсЭм ХХК-н үйлдвэрийн дотоод болон гадаад орсноос агаарын сорьц цуглуулсан.

Түүвэр дээж цуглуулсан цэгийн тоо /Number of sampling point/: 3

Түүвэр дээжийн тоо /Number of sample/: 8

Сорьц цуглуулсан арга /Sampling method/: MNS 3384:1982

Түүвэр дээж цуглуулсан хүн /Sample is collected by/: С.Одбаяр

Түүвэр дээж цуглуулсан огноо <i>Date of collected</i>	Лабораторид хүлээн авсан огноо <i>Date of receipt</i>	Сорилт эхэлсэн огноо <i>Date of test started</i>	Сорилт дууссан огноо <i>Date of test completion</i>	Хэвлэсэн огноо <i>Date of issue of the report</i>
2022-06-17	2022-06-17	2022-06-20	2022-06-27	2022-06-30

Сорилтын дүн <i>Test report</i>				
Түүвэр дээжийн дугаар <i>Sample number</i>	Тодорхойлох үзүүлэлт <i>Test parameter</i>	Сорилтын аргын стандарт <i>Method of analysis</i>	Сорилтын дүн, хэмжих нэгж <i>Test results, unit</i>	Байршил <i>Collected location</i>
4338	Азотын давхар исэл <i>NO2</i>	MNS ISO 6768:2005	30.9 мкг/м³ <i>µg/m³</i>	Химийн агуулах
4339	Азотын давхар исэл <i>NO2</i>	MNS ISO 6768:2005	62.3 мкг/м³ <i>µg/m³</i>	Үйлдвэрийн агуулахын гадаа
4340	Азотын давхар исэл <i>NO2</i>	MNS ISO 6768:2005	46.9 мкг/м³ <i>µg/m³</i>	Бетон нэмэлтийн үйлдвэр
4346	Хүхэрлэг хий <i>Sulfur dioxide SO2</i>	ISO 6767:1990	154.1 мкг/м³ <i>µg/m³</i>	Химийн агуулах
4347	Хүхэрлэг хий <i>Sulfur dioxide SO2</i>	ISO 6767:1990	61.4 мкг/м³ <i>µg/m³</i>	Үйлдвэрийн агуулахын гадаа
4348	Хүхэрлэг хий <i>Sulfur dioxide SO2</i>	ISO 6767:1990	116.6 мкг/м³ <i>µg/m³</i>	Бетон нэмэлтийн үйлдвэр

Лабораторийн дотоод хяналт <i>Quality control</i>			
№	Нэгдлийн нэр <i>Test parameter</i>	Стандарт уусмалын агуулга <i>Reference concentration</i>	Сорилтын утга, хэмжих нэгж <i>Test results, unit</i>
1	Азотын давхар исэл <i>NO2</i>	0.600	0.616 мкг/мл <i>µg/ml</i>
2	Хүхэрлэг хий <i>Sulfur dioxide SO2</i>	16.769	17.102 мкг <i>µg</i>

2022 оны 10 сарын 05-ны агаарын дээжийн хариунууд

10/14/22, 11:52 AM

Green-Crown LIMS v1.0

НОГООН ТИТЭМ ХХК-н захирлын
2020 оны 12 сарын 25-ний өдрийн
2020/2-1 дугаар тушаалын хавсралт



НОГООН ТИТЭМ ХХК
Хан-Уул дүүрэг, 3-р хороо,
Сан-Контрактин ХХК байр, 222 тоот.
Утас: 70005432



ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ТАЙЛАН
TEST REPORT OF LABORATORY

Ажлын дугаар /Registration number/ : 221004

Сорилтын төрөл /The type of test/ : Агаар Air

Захиалагчийн мэдээлэл : МСМ групп ХХК

/The name of customer's request for analysis/

Түүвэр дээжийн мэдээлэл /Sample details/ : МСМ групп ХХК-ний хүсэлтээр тус үйлдвэрийн гадаад болон дотоод орчноос агаарын сорьц цуглуулсан.

Түүвэр дээж цуглуулсан цэгийн тоо /Number of sampling point/ : 3

Түүвэр дээжийн тоо /Number of sample/ : 8

Сорьц цуглуулсан арга /Sampling method/ : MNS 3384:1982

Түүвэр дээж цуглуулсан хүн /Sample is collected by/ : С.Одбаяр

Түүвэр дээж цуглуулсан огноо <i>Date of collected</i>	Лабораторид хүлээн авсан огноо <i>Date of receipt</i>	Сорилт эхэлсэн огноо <i>Date of test started</i>	Сорилт дууссан огноо <i>Date of test completion</i>	Хэвлэсэн огноо <i>Date of issue of the report</i>
2022-10-05	2022-10-05	2022-10-05	2022-10-11	2022-10-14

Сорилтын дүн <i>Test report</i>				
Түүвэр дээжийн дугаар <i>Sample number</i>	Тодорхойлох үзүүлэлт <i>Test parameter</i>	Сорилтын аргын стандарт <i>Method of analysis</i>	Сорилтын дүн, хэмжих нэгж <i>Test results, unit</i>	Байршил <i>Collected location</i>
5281	Азотын давхар исэл <i>NO2</i>	MNS ISO 6768:2005	18.21 мкг/м³ <i>µg/m³</i>	Үйлдвэрийн агуулахын гадна
5282	Азотын давхар исэл <i>NO2</i>	MNS ISO 6768:2005	12.32 мкг/м³ <i>µg/m³</i>	Химийн агуулах
5283	Азотын давхар исэл <i>NO2</i>	MNS ISO 6768:2005	52.07 мкг/м³ <i>µg/m³</i>	Бетон нэмэлтийн үйлдвэр
5284	Хүхэрлэг хий <i>Sulfur dioxide SO2</i>	ISO 6767:1990	<20 мкг/м³ <i>µg/m³</i>	Үйлдвэрийн агуулахын гадна
5285	Хүхэрлэг хий <i>Sulfur dioxide SO2</i>	ISO 6767:1990	<20 мкг/м³ <i>µg/m³</i>	Химийн агуулах
5286	Хүхэрлэг хий <i>Sulfur dioxide SO2</i>	ISO 6767:1990	205.91 мкг/м³ <i>µg/m³</i>	Бетон нэмэлтийн үйлдвэр

Лабораторийн дотоод хяналт <i>Quality control</i>			
№	Нэгдлийн нэр <i>Test parameter</i>	Стандарт уусмалын агуулга <i>Reference concentration</i>	Сорилтын утга, хэмжих нэгж <i>Test results, unit</i>
1	Азотын давхар исэл <i>NO2</i>	0.600	0.610 мкг/мл <i>µg/ml</i>
2	Хүхэрлэг хий <i>Sulfur dioxide SO2</i>	16.228	16.376 мкг <i>µg</i>

elab.greencrown.mn/generalTestPage#

1/2

Дээрх сорилтын дүнгээс үзэхэд химийн агуулахын гадаад болон дотоод орчны азотын давхар исэл, хүхэрлэг хийн агууламж Монгол улсын агаарын чанарын MNS4585:2016 стандарт болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага MNS4990:2015 стандартын хүлцэх агууламжаас хэтрээгүй байна.


13.3 УС

2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ОХШХ-ийн хүрээнд ундны усан дахь эмгэг төрүүлэгч бактерийн тоо, ундны усны бүрэн шинжилгээ, ундны усан дахь хүнд металлын агууламж тодорхойлохоор дээж авч итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлээ.



Зураг 25. Химийн оффисын усны цоргоос дээж авсан.

Доорх лабораторийн хариунаас харахад ундны усан дахь эмгэг төрүүлэгч бактерийн тоо, ундны усны бүрэн шинжилгээ, ундны усан дахь хүнд металлын агууламж жилд нэг удаа үзсэн ямар нэгэн нян илрээгүй.




TL 092
MNS ISO 17025

УСНЫ ХЯНАЛТЫН ТӨВ ЛАБОРАТОРИ

/Central inspection laboratory/
Улаанбаатар хот Баянгол дүүрэг 2-р хороо Чингүнжавын гудамж
Утас 70180075

**ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН
СОРИЛТЫН ДҮНГИЙН ХУУДАС**
/ Test result of accredited laboratory /



“МОНГОЛ – УС” ТӨҮГ
/MONGOL-US/

Захиалагчийн нэр / Customer name /: “MSM Group” LLC

Шинжилгээний тодорхойлолт /Analysis type/	Дээжний дугаар /Test number/	Дээжний хаяг, байршил /Sample location/	Уст цэгийн төрөл /Type of water/	
Цэвэр усны хими	№ 661	УБ хот, ХУД, 3-р хороо	Төвлөрсөн шугам	-

Дээжний хэмжээ /Quantity of sample/	Дээж хүлээн авсан огноо /Receiving date/	Шинжилсэн огноо /Analyzing date/	Хэвлэсэн огноо /Printed date/	Техникийн шаардлага /Technical requirements/
1.5 л/ 1.5l	2022.06.08	2022.06.13	2022.06.17	MNS 0900:2018

№	Үзүүлэлт /Parameters/	Шинжлэх аргын стандарт /Test method/	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ /Technical specification/	Үр дүн / Test result/
1	pH-Усны орчин /Hydrogen ions/	MNS ISO 10523-2001	6.5-8.5	7.11
2	Цахилгаан дамжуулах чанар, мСм/см /Electrical conductivity/	MNS ISO 7888:1999	<1.0	0.82
3	Ерөнхий хатуулаг, мг-экв/л /Total hardness, mg-eq/L/	MNS ISO 6059:2005	<7.0	7.36
4	Кальци, (Ca ²⁺) мг/л /Calcium ion, mg/L/	MNS 1097:1970	<100.0	133.90
5	Магни, (Mg ²⁺) мг/л /Magnesium ion, mg/L/	MNS 1097:1970	<30.0	8.27
6	Карбонат, (CO ₃ ⁻) мг/л /Carbonate ion, mg/L/	MNS ISO 9963-1:2005	-	0.00
7	Хлорид, (Cl ⁻) мг/л /Chloride ion, mg/L/	MNS ISO 9297:2005	<350.0	36.16
8	Гидрокарбонат, (HCO ₃ ⁻) мг/л /Hydrocarbon ion, mg/L/	MNS ISO 9963-1:2005	-	97.60
9	Нитрит, (NO ₂ ⁻) мг/л /Nitrite ion, mg/L/	MNS 4431-2005	<1.0	0.00
10	Нитрат, (NO ₃ ⁻) мг/л /Nitrate ion, mg/L/	MNS ISO 7890-3:2001	<50.0	3.95
11	Төмөр, (Fe ³⁺) мг/л /Ferrium ion, mg/L/	MNS 4430:2005	<0.3	0.06
12	Сульфат, (SO ₄ ²⁻) мг/л /Sulfate ion, mg/L/	MNS 6271:2011	<500.0	252.00
13	Хуурай үлдэгдэл, мг/л /TDS, mg/L/	MNS 4423:1997	<1000.0	567.00
14	Натри +Кали, (Na ⁺ , K ⁺) /Sodium+Potassium ion, mg/L/	MNS 1097:1970	<200	13.19
15	Аммони, (NH ₄ ⁺) мг/л /Ammonia ion, mg/L/	MNS 1097:1970	<1.5	0.06

Шинжилгээ гүйцэтгэсэн /Test performed by/:


Химич /Chemist/ Д. Урантэс /Urantess D/

Хянасан /Approved/:

Лабораторийн эрхлэгч /Head of laboratory/ Б. Хулагчин /Khulagchin B MSc/

Хуудас/ page: 1/1

Энэхүү сорилтын дүн нь тухайн дээжний хувьд хүчинтэй. (The test result report is applicable to the sample/
Сорилтын лабораторийн зөвшөөрөлгүйгээр хуулбарлахыг хориглоно. /It is prohibited to reproduce the results without laboratory authorization/




TL 092
MNS ISO 17025

УСНЫ ХЯНАЛТЫН ТӨВ ЛАБОРАТОРИ
/Central inspection laboratory/

Улаанбаатар хот Баянгол дүүрэг 2-р хороо Чингүржавын гудамж
Утас:70180075

**ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН
СОРИЛТЫН ДҮНГИЙН ХУУДАС**
/ Test result of accredited laboratory /



'МОНГОЛ – УС' ТӨҮГ
/MONGOL-US/

Захиалагчийн нэр /Customer name/ : “МСМ ГРУПП” ХХК

Шинжилгээний тодорхойлолт <i>/Analysis type/</i>	Дээжний дугаар <i>/Test number/</i>	Дээжний хаяг, байршил <i>/Sample location/</i>	Уст цэгийн төрөл <i>/Type of water/</i>	
Цэвэр усны микробиологи	№661	ХУД, 3-р хороо	Төвлөрсөн шугам	-

Дээжний хэмжээ <i>/Quantity of sample/</i>	Дээж хүлээн авсан огноо <i>/Receiving date/</i>	Шинжилсэн огноо <i>/Analyzing date/</i>	Хэвлэсэн огноо <i>/Printed date/</i>	Техникийн шаардлага <i>/Technical requirements/</i>
0.5 л / 0.5l /	2022.06.08	2022.06.08-06.10	2022.06.10	MNS 0900:2018

№	Шинжилсэн үзүүлэлт, хэмжих нэгж <i>/Parameters/</i>	Шинжилгээний аргын стандарт <i>/Test method/</i>	*ЗДХ <i>/Technical specification/</i>	Үр дүн <i>/Test result/</i>
1	Нийт нянгийн тоо- <i>Total number of microorganisms/ Colony-Forming Unit, CFU</i>	MNS ISO 6222:1998	<100	0
2	Гэдэсний бүлгийн савханцар, халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн савханцар <i>/Coliforms organisms, Thermotolerant coliform organisms and E.coli/</i>	MNS (ISO) 9308-2:1998	Илрэхгүй <i>Undetect</i>	Илрээгүй <i>Undetected</i>
3	Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч бичил биетэн- <i>Salmonella, Shigella</i> <i>/Pathogenic organisms- Salmonella, Shigella/</i>	MNS 6340:03	Илрэхгүй <i>Undetect</i>	Илрээгүй <i>Undetected</i>
4	Сульфид задлагч агааргүйтэн - <i>Cl.perfringens</i> <i>/Sulfide-reducing anaerobes- Cl.perfringens/</i>	MNS 6461-1:1999	Илрэхгүй <i>Undetect</i>	Илрээгүй <i>Undetected</i>
5	Псевдомонас аерогиноза- <i>Pseudomonas aeruginosa/</i>	MNS 6546:2015	Илрэхгүй <i>Undetect</i>	Илрээгүй <i>Undetected</i>

* ЗДХ- Зөвшөөрөгдөх дээд хэмжээ

Шинжилгээ гүйцэтгэсэн /Test performed by/ :
Микробиологич /Microbiologist/



..... Д. Оюунтуяа /Oyuntuya.D/


Хянасан /Approved/:

Лабораторийн эрхлэгч /Head of laboratory/

..... Б. Хулагчин /Khulagchin B.MSc/

Хуудас/ page: 1/1

Энэхүү сорилтын дүн нь тухайн дээжний хувьд хүчинтэй. /The test result report is applicable to the sample/
Сорилтын лабораторийн зөвшөөрөлгүйгээр хуулбарлахыг хориглоно. /It is prohibited to reproduce the results without laboratory authorization/




TL 092
MNS ISO 17025

ХЯНАЛТЫН ТӨВ ЛАБОРАТОРИ

/Central inspection laboratory/
Улаанбаатар хот Баянгол дүүрэг 3-р хороо
Чингүнжавын гудамж Утас:70180075

СОРИЛТЫН ДҮНГИЙН ХУУДАС
/ Test result of accredited laboratory /



“МОНГОЛ – УС” ТӨҮГ
/MONGOL-US/

Захиалагчийн нэр /Customer name/: “MSM Group” ХХК

Дээжний дугаар /Test number/	Дээжний хаяг, байршил /Sample location/			Уст цэгийн төрөл /Type of water/
№ 661	УБ хот, ХУД, 3-р хороо			Төвлөрсөн шугам -
Дээжний тоо, хэмжээ /Quantity of the sample/	Дээж хүлээн авсан огноо /Date receipt/	Шинжилсэн огноо /Analyzing date/	Хэвлэсэн огноо /Printed date/	Техникийн шаардлага / Technical requirements/ MNS 0900 2018
0.5 л / 0.5 л /	2022.06.08	2022.06.13-06.23	2022.06.23	Шинжгээний аргын стандарт /Test method/ MNS ISO 11885:2011 /ICP/

№	Үзүүлэлт /Parameters/	ЗДХ /Technical specification/ мг/л	Үр дүн /Test result/	№	Үзүүлэлт /Parameters/	ЗДХ /Technical specification/ мг/л	Үр дүн /Test result/
1	Манган, (Mn) мг/л /Manganese, Mn, mg/L /	<0.1	<0.005	11	Хөнгөнцагаан, (Al), мг/л /Aluminum, Al, mg/L /	<0.5	<0.01
2	Никель, (Ni) мг/л /Nickel, Ni, mg/L /	<0.02	<0.005	12	Лити, (Li) мг/л /Lithium, Li, mg/L /	-	<0.005
3	Зэс, (Cu) мг/л /Copper, Cu mg/L /	<2.0	<0.005	13	Барий, (Ba) мг/л /Barium, Ba, mg/L /	<0.7	<0.01
4	Кадми, (Cd) мг/л /Cadmium, Cd mg/L /	<0.003	0.001	14	Мөнгө, (Ag) мг/л /Silver, S, mg/L /	<0.1	<0.005
5	Кобальт, (Co) мг/л /Cobalt, Co, mg/L /	-	<0.005	15	Бор, (B) мг/л /Bor, B, mg/L /	<2.4	<0.005
6	Хар тугалга, Pb мг/л /Lead, Pb mg/L /	<0.01	<0.005	16	Галли, (Ga) мг/л /Gallium, Ga, mg/L /	-	<0.005
7	Цайр, (Zn) мг/л /Zinc, Zn, mg/L /	<5.0	0.009	17	Стронци, (Sr) мг/л /Strontium, Sr, mg/L /	<2.0	0.061
8	Нийт хром (Cr) мг/л /Chromium, Cr, mg/L /	<0.05	<0.01	18	Инди, (In) мг/л /Indium, In, mg/L /	-	<0.005
9	Нийт төмөр (Fe) мг/л /Iron, Fe, mg/L /	<0.3	0.06	19	Талли, (Tl) мг/л /Tallium, Tl mg/L /	-	<0.005
10	Бисмут, (Bi) мг/л /Bismuth, Bi, mg/L /	-	<0.005	20	Ванади, V мг/л /Vanadium, V mg/L /	-	<0.01

Шинжилгээ гүйцэтгэсэн /Test performed by/:

Химич /Chemist/ Д. Урантэс / Urantes D /

Хянасан /Approved/:

Лабораторийн эрхлэгч / Head of laboratory/ Б. Хулагчин / Khulagchin B MSc/

Хуудас 1/1

Энэхүү сорилтын дүн нь тухайн дээжний хувьд хүчинтэй. /The test result report is applicable to the sample/
Сорилтын лабораторийн зөвшөөрөлгүйгээр хуулбарлахыг хориглоно. /It is prohibited to reproduce the results without laboratory authorization/

14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ

№	Товлосон хугацаа	Хаана	Тайлбар
1	2022 оны 11-р сарын 1	Нийслэлийн Байгаль орчны газар	2022 оны төлөвлөгөөний биелэлтийг хэлэлцүүлэх
2	2022 оны 12-р сарын 1	БОАЖЯ-ны ХБОБНУГ-т	2022 оны төлөвлөгөөг батлуулах

15. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ГАРГАСАН НИЙТ ЗАРДАЛ

“МСМ ГРУПП ХХК”-ИЙН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ЗАРЦУУЛСАН НИЙТ ХӨРӨНГӨ

№	Менежментийн төлөвлөгөө	Зардлын хэмжээ
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай НБХХ гарсан зардал	7.500.000
2	Нөхөн сэргээлт, орчны тохижилтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гарсан зардал -Тарьсан мод бутыг арчлах усалгаа - Мод тарьсан	2.000.000
3	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гарсан зардал -Ахуйн болон Химийн бодисын хог хаягдал -Цэцүүх Трейд руу химийн хог хаягдал шилжшүүлсэн.	24.101.954+ /2022 оны 10 дугаар сарын байдлаар/
4	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гарсан зардал -Химийн бодистой харьцах сургалт -Анхны тусламж үзүүлэгч ажилчдыг Интермед эмнэлэгт сургалтанд хамруулсан. - Агуулахын гал унтраах багаж хэрэгслүүдийг бүрдүүлж, шинээр худалдан авалт хийгдсэн.	1.500.000
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд гарсан зардал	3.591.500
	НИЙТ ГАРСАН ЗАРДАЛ:	38,693.454

ХАВСРАЛТУУД

1. ХАЯГДАЛ ТОСЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ГЭРЭЭ “ХАЙ БИ ОЙЛ” ХХК
2. ЭКО ОРЧИН ХХК-ТАЙ ХОГ ХАЯГДЛЫН ГЭРЭЭ
3. ЦЭЦҮҮХ ТРЕЙД ХХК-НИЙ ХИМИЙН БОДИСЫН ХОГ ХАЯГДЛЫГ УСТГАХ
ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ
4. МСМ ГРУПП ХХК –НИЙ ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДҮГНЭЛТ
5. МСМ ГРУПП ХХК-НИЙ ГАЛЫН ИДЭВХИТЭН БОЛОН АНХНЫ ТУСЛАМЖ
ҮЗҮҮЛЭГЧ АЖИЛТНУУД
6. МСМ ГРУПП ХХК-НИЙ ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕД ХОЛБОГДОХ УТАСНЫ
ЖАГСААЛТ

ХАВСРАЛТ 1



БАТЛАВ:
“МСМ ГРУПП” ХХК-ИЙН
УДИРДАХ ЗАХИРАЛ

Ш.НУРМАА



ТЕХНИКИЙН ХАЯГДАЛ ТОС (АХХ) НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

2017 оны 03-р сарын 22-ний өдөр

№ VS-17/001

Улаанбаатар хот

Энэхүү гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г 134 тоот регистрийн, 90100011063 тоот улсын бүртгэлийн дугаартай “Хай Би Ойл” ХХК-г төлөөлж Менежер ажилтай Д.Тогосбаатар, нөгөө талаас Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа 2560526 регистрийн, 9019009002 тоот улсын бүртгэлийн дугаартай “МСМ Групп” ХХК-г төлөөлж Автомотивын борлуулалтын дараах засвар, үйлчилгээ хариуцсан захирал нар дор дурдсан зүйлийг харилцан тохиролцсоны үндсэн дээр Монгол Улсын Иргэний /243-261, 476-480-р/ хуулийн холбогдох зүйл заалтыг баримтлан энэхүү техникийн ажилласан тос (АХХ) нийлүүлэх гэрээг байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү гэрээгээр “МСМ Групп” ХХК нь “Хай Би Ойл” ХХК-д Гэрээний хугацаанд машин механизмын, тоног төхөөрөмжийн, хөдөлгүүрийн, гидрийн болон моторын тосыг солих үед гарсан техникийн хаягдал тос буюу аюултай хог хаягдал /цаашид “АХХ” гэх/-г цуглуулж нийлүүлэх ба “Хай Би Ойл” ХХК нь түүнд тохирох үнийг төлөх болон бусад холбогдох харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Энэхүү гэрээ нь өмнө нь талуудын хооронд хийгдсэн бүх тохиролцоог агуулж байгаа бөгөөд Гэрээг зохицуулсан харилцааны хүрээнд талуудын өмнө хийсэн хэлцэл, мэдэгдэл, аман болон бичгээр хийсэн тохиролцоог энэхүү гэрээ орлож байгаа болно.
- 1.3 Энэхүү гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэж, хоёр тал гарын үсэг зурснаар үндсэн гэрээний адил хүчинтэйд тооцогдоно.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА, НИЙЛҮҮЛЭХ НӨХЦӨЛ

- 2.1 Энэхүү гэрээ нь “Хай Би Ойл” ХХК болон “МСМ Групп” ХХК-ийн төлөөлөгчдийн гарын үсэг зурагдснаар хүчин төгөлдөр болох бөгөөд 1 жилийн хугацаанд хүчинтэй. Гэрээний хугацаа дуусахад аль нэг тал гэрээг дуусгавар болгох талаар аливаа санал, шаардлага илэрхийлээгүй тохиолдолд Гэрээг мөн хугацаагаар сунгагдсанд тооцно.
- 2.2 Нийлүүлэх, хүлээн авах: “Хай Би Ойл” ХХК нь “МСМ Групп” ХХК-ийн дуудлага хийснээс хойш ажлын 1 хоногийн дотор АХХ-г “МСМ Групп” ХХК-ийн цуглуулгын талбайгаас хүлээн авах ба хүлээлцэх үедээ АХХ-ын тоо хэмжээг хүлээлцэх актад тодорхой тусгана.
- 2.3 АХХ-г Гэрээний 2.2-т заасны дагуу хүлээлгэн өгснөөр түүнд үүсч болох аливаа эрсдэл “Хай Би Ойл” ХХК-д шилжинэ.

ГУРАВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1 Талууд бие биенээсээ энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, хэрэгжүүлэхийг шаардах бүрэн эрхтэй.

- 3.2 Талууд АХХ-г юүлэх, зөөх, тээвэрлэх, машинд ачиж буулгах зэрэг АХХ-г хөдөлгөөнт тухай бүрт хариуцлагатай байж, ажлын болон агуулахын талбай, газар шороо байгаль орчинг бохирдуулахгүй байхад шаардлагатай арга хэмжээг авч хяналт тавьж ажиллах үүрэгтэй.
- 3.3 АХХ буюу техникийн хаягдал тосыг “МСМ Групп” ХХК нь ямар нэг биет хог /эрэг, боолт, төмөр, чулуу, хуванцар, даавуу, гялгар уут гэх мэт/, механик хольц болон хөргөлтийн шингэн /тосол/, хурдны хайрцагны тос /АКТ/-ны хольцгүйгээр аль болох нэг төрлөөр цуглуулж хүлээлгэн өгөх үүрэгтэй.
- 3.4 “Хай Би Ойл” ХК нь “МСМ Групп” ХХК -ийн цуглуулан ангилж буй АХХ буюу техникийн хаягдал тосны чанарын асуудлаар “МСМ Групп” ХХК-дбичгээр санал, шаардлага хүргүүлэх эрхтэй.
- 3.5 “Хай Би Ойл” ХК нь АХХ-н тээвэрлэлт, ачилтын асуудалд үүсэх эрсдлийг хариуцаж, “МСМ Групп” ХХК-ийн дуудлагын дагуу “МСМ Групп” ХХК-ийн цуглуулгын талбайгаас бүрэн зориулалтын техникээр тээвэрлэн өөрийн АХХ-ын цуглуулгын цэг рүү тээвэрлэх үүрэгтэй.
- 3.6 Энэхүү гэрээний дагуу өгөх шаардлагатай эсхүл өгөхийг зөвшөөрсөн аливаа мэдэгдлийг бичгээр үйлдэх бөгөөд түүнийг биечлэн хүргүүлэх эсхүл Гэрээнд заасан цахим шуудангийн хаягаар илгээсэн тохиолдолд хүлээн авагч тал хүлээн авсан нөхцөлд түүнийг өгсөнд тооцно. Биечлэн хүргүүлсэн аливаа мэдэгдлийг хүлээж авснаа талууд бичгээр хариу мэдэгдэж санхүүгийн анхан шатны баримт үйлдэн баталгаажуулах үүрэгтэй.
- 3.7 “Хай Би Ойл” ХК нь “МСМ Групп” ХХК-аас хүлээн авсан АХХ-ыг энэ гэрээний 3.3-т заасан шаардлагад нийцсэн эсэхийг өөрийн лабораторт судалж, шинжилсний үндсэн дээр хорогдол тооцон авах эрхтэй. МСМ Групп ХХК нь тус лабораторийн шинжилгээг эс зөвшөөрвөл хөндлөнгийн шинжээчээр шинжлүүлэх эрхтэй ба буруутай тал хөндлөнгийн шинжээчтэй холбоотой зардлыг хариуцна.
- 3.9 Тал тус бүр Гэрээг биелүүлэх үедээ хөдөлмөрийн болон эрүүл ахуйн дүрэм журам, зааврыг чанд баримтлах ба тус тусын ажилтнуудын хөдөлмөрийн болон эрүүл ахуйн аюулгүй байдлыг бүрэн хариуцна.
- 3.8 Энэхүү гэрээ байгуулсантай холбогдон олж авсан талуудтай холбоотой мэдээлэл, баримтын нууцлалыг Гэрээ байгуулснаас хойш хоёр тал хугацаагүйгээр чанд хадгалах бөгөөд аль нэг тал нөгөө талд зөвшөөрөл олгосон эсвэл хууль тогтоомжийн дагуу шаардсанаас бусад тохиолдолд аливаа гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй байх, гэрээнд заагдаагүй зорилгоор ашиглахгүй байх үүрэгтэй.

ДӨРӨВ. ТӨЛБӨР, ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

- 4.1 “МСМ Групп” ХХК -ийн нийлүүлж буй шаардлага хангасан АХХ-н нэг тонн тутмыг 150’000 (нэг зуун тавин мянга) төгрөгөөр (НӨАТ орсон) худалдан авах ба талуудын хүлээлгэн өгсөн болон хүлээн авсан ажилтнуудын гарын үсгээр баталгаажсан хүлээлцэх акта-д бичигдсэн хэмжээг үндэслэн тооцно.
- 4.2 АХХ-н нийлүүлэлтийн тооцоог улирал тутамд дараагийн сарын 5-ны өдрийн дотор нийлж, төлбөрийг “МСМ Групп” ХХК-ийн Голомт банкны 110 204 7960 тоот төгрөгийн дансанд нэхэмжлэлийн дагуу улирал бүр дараагийн сарын 15-ны өдрийн дотор шилжүүлнэ.
- 4.3 “Хай Би Ойл” ХК нь Гэрээнд заасан төлбөрөө төлөөгүй бол “МСМ Групп” ХХК нь дараагийн нийлүүлэлтийг тухайн хойшлогдсон хугацааар хойшлуулж болно:
- 4.4 “Хай Би Ойл” ХХК нь Гэрээний төлбөрийг цаг тухай бүр гүйцэтгэх үүрэгтэй ба ийнхүү гүйцэтгээгүй тохиолдолд хоног тутам гүйцэтгээгүй үнийн дүнгийн 0,3 хувьтай тэнцэх алданги оногдуулна.

ТАВ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 5.1 Ямар ч тохиолдолд аль нэг тал түүний хяналтаас гарсан аливаа шалтгаан эсхүл нөхцөл байдлын улмаас шууд эсхүл шууд бус байдлаар, бүхэлд нь эсхүл хэсэгчлэн энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж чадаагүй эсхүл үүргийн биелэлт нь хойшлогдсон тохиолдолд нөгөө талын өмнө хариуцлага хүлээхгүй.
- 5.2 Тийм шалтгаан, нөхцөл байдалд: гал түймэр, үер, ажил хаялт, үймээн, хорлон сүтгэх ажиллагаа, дэлбэрэлт, цаг уурын сөрөг нөхцөл, зайлсхийх боломжгүй золгүй явдал, ажиллах хүч, материал, тээвэр эсхүл үйлчилгээ олдохгүй байх, давагдашгүй хүчин зүйлс эсхүл дайсагнагч улсын үйл ажиллагаа, нөгөө талын үйлдэл, шүүхийн шийдвэр, тушаал, тогтоол эсхүл Засгийн газрын эрх бүхий байгууллагын журам эсхүл зөвшөөрлийг алдах явдал бөгөөд энэ бүхэн аль ч талын үйлдэлд үндэслэгдээгүй байх ёстой.
- 5.3 Дээрхээс шалтгаалах ажил зогсоолт эсхүл энэ гэрээний дагуу үзүүлэх үйлчилгээний гүйцэтгэл тасалдсаны улмаас цаг хугацааны хувьд хойшлогдох асуудлыг аль болох яаралтай засаж залруулна.

ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ

- 6.1 Энэхүү гэрээг хоёр хувь үйлдэж, талууд гарын үсэг зурж, тамга тэмдэг даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 6.2
- 6.3 Энэхүү гэрээнд заасан хэлцлүүд хэрэгжсэн эсэхийг үл харгалзан гэрээнд тусгагдсан болон гэрээг бэлтгэх, хэрэгжүүлэх үед гэрээнд оролцогч талуудын зүгээс гарсан аливаа зардлыг талууд өөр өөрсдөө хариуцна.

ДОЛОО. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

- 7.1 Талууд харилцагч талынхаа бизнесийн нэр хүндийг хүндэтгэж, тэгш эрхийн зарчимд тулгуурлан ажиллана.
- 7.2 Талууд гэрээний хугацаанд харилцан ашигтай, найрсаг байдлаар хамтран ажиллаж аливаа маргааныг зөвшилцлийн замаар шийдвэрлэх бөгөөд хэрэв тодорхой зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хуулийн дагуу харьяалагдах шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭГ БАЙГУУЛСАН:

ХҮЛЭЭН АВАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:

“Хай Би Ойл” ХК-ийн
Менежер Д.Тогосбаатар


/гарын үсэг/

УБ хот, СХДүүрэг, 20-р хороо,
Сонсголонгийн /18135/ 110

Утас:


Гар утас: +976 - 9116 7117

И-майл хаяг: togosbaatar@hboil.mn

Вэб: www.hboil.mn

НИЙЛҮҮЛЭГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:

“МСМ Групп” ХХК -ийн
Борлуулалтын дараах засвар, үйлчилгээ
хариуцсан захирал Барун Синха


/гарын үсэг/

Улаанбаатар хот, ХУД, 3-р хороо, Чингисийн
өргөн чөлөө 62, Үйлдвэрийн бүс /17070/

Утас/Факс: +976 - 7718 1111, 11-342 175

Гар утас: +976 - 99025539

И-майл хаяг: barun@msmco.net

Вэб: www.msmgroup.mn

ХАВСРАЛТ 2

<p>БАТЛАВ. “МСМ ГРУПП” ХХК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАХИРАЛ <i>Г.Дариймаа</i> Э.БОЛОРМАА УЛААНБААТАР ХОТ ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАЙ</p>	<p>БАТЛАВ. ТАР ХОТ “ЭКО ОРЧИН” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ <i>О.Есөнтөмөр</i> О.ЕСӨНТӨМӨР ХХК ТТ03890-0-5434459</p>	
<p>ЭНГИЙН БОЛОН ДАХИВАР ХОГ, ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ</p>		
<p>2022 оны 2 сарын 18 ны өдөр</p>	<p>№ <i>22/010</i></p>	<p>Улаанбаатар хот</p>
<p>Энэхүү Энгийн болон дахивар хог хаягдал тээвэрлэх үйлчилгээ үзүүлэх гэрээ (цаашид “Гэрээ” гэх) нэг талаас Улсын бүртгэлийн 9019009002 дугаарт бүртгэгдсэн, 2560526 тоот регистрийн дугаартай Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө 62 хаягт орших “МСМ ГРУПП” ХХК (цаашид “Захиалагч” гэх) –ийг төлөөлөн Захиргааны менежер Г.Дариймаа,</p>		
<p>нөгөө талаас Улсын бүртгэлийн 9011262128 дугаарт бүртгэгдсэн, 5434459 тоот регистрийн дугаартай, Баянгол дүүрэг, 5-р хороо, ажилчны гудамж 80/1 тоот хаягт орших “Эко орчин” ХХК (цаашид “Гүйцэтгэгч” гэх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал О.Есөнтөмөр (цаашид хамтад нь “Талууд” гэх) нар Монгол Улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хуулийг тус тус удирдлага болгон дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.</p>		
<p>Нэг. Нийтлэг үндэслэл</p>		
<p>1.1 Энэхүү гэрээгээр Гүйцэтгэгч нь Хан-Уул дүүргийн 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө-62 тоот хаягт байрлах Захиалагчийн байрнаас дахивар болон бусад хог хаягдлыг мөн Гэрээнд заасны дагуу тусгайлсан захиалгын дагуу Захиалагчийн нэр зааж захиалсан газраас барилгын хог хаягдлыг тээвэрлэж, зориулалтын цэгт хүргэхтэй холбоотойгоор Талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулна.</p> <p>1.2 Гэрээнд заасан дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:</p> <p>1.2.1 “Дахивар хог хаягдал” гэж дахин ашиглагдах, дахин боловсруулах, сэргээн ашиглагдах хог хаягдлыг;</p> <p>1.2.2 “Бусад хог хаягдал” гэж дахивар хог хаягдлаас бусад энгийн хог хаягдлыг;</p> <p>1.2.3 “Барилгын хог хаягдал” гэж барилгын суурь бэлтгэх, барилга барих, засварлах, буулгах болон авто зам барих, засварлахад үүсэх хог хаягдал, явган хүний зам талбай, ногоон байгууламжийн тохижилт, инженерийн шугам сүлжээ тавих, засварлах, солих үед үүсэх хог хаягдал болон барилгын материалын худалдаа, үйлдвэрлэлээс гарах хог хаягдлыг;</p> <p>1.3 Гэрээнд Гүйцэтгэгчийн дараах баримт бичгүүдийг хавсаргах бөгөөд эдгээр нь Гэрээний салшгүй хэсэг байна. Үүнд:</p> <p>1.3.1 Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ</p> <p>1.3.2 Эрх бүхий этгээдтэй байгуулсан Хог хаягдал тээвэрлэх тухай гэрээ</p>		
<p>Хоёр. Хог хаягдал тээвэрлэх, төлбөр, тооцоо хийх журам</p>		
<p>2.1 Гүйцэтгэгч нь Гэрээний 2.5-д заасан хуваарь болон нэмэлт захиалгын дагуу Захиалагчийн дахивар хог хаягдал болон бусад хог хаягдлыг Захиалагчийн Хан-Уул дүүргийн 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө-62 тоот хаягт байрлах байр (цаашид “Талбай” гэх)-наас, мөн тусгайлсан дуудлагын дагуу барилгын хог хаягдлыг Захиалагчийн заасан цэгээс зориулалтын тээврийн хэрэгслээр очиж ачин Гэрээнд заасан цэг рүү тээвэрлэн хүргэнэ.</p> <p>2.2 Гүйцэтгэгч нь дахивар хог хаягдлыг-т байрлах <i>А.204/11</i> цэг рүү, бусад хог хаягдлыг-т байрлах <i>Уулсын габас</i> цэг рүү, барилгын хог хаягдлыг <i>Уулсын цэг рүү</i> ачиж тээвэрлэж, зохих ёсоор буулгана.</p> <p>2.3 Гүйцэтгэгч нь Тээвэрлэлт хийх бүрт Захиалагчийн АБЭЦЦХХянагч эсвэл ээлжийн харуулаар гарын үсэг зуруулж баталгаажуулах бөгөөд хог хаягдал ачсан талаарх тээврийн тооцоо, замын хуудсыг тухай бүр нь Захиалагчид гаргаж өгнө.</p>		
<p><i>Г.Дариймаа</i></p>	<p>Талуудын гарын үсэг</p>	<p><i>О.Есөнтөмөр</i></p>

2.4 Захиалагч нь батлагдсан хуваарийн дагуу хог ачуулахаас гадна шаардлагатай тохиолдолд хог хаягдлыг нэмэлтээр дуудлага өгөх эрхтэй. Нэмэлтээр дуудлага өгч байгаа тохиолдолд гэрээнд тохирсон үнийн дүнд өөрчлөлт орохгүй байна. Дуудлагаар хог ачуулах бол 1 хоногийн өмнө дуудлага өгнө.

2.5 Хог хаягдал тээвэрлэлтийн төлбөр:

№	Хогны төрөл	Давтамж	Ачилт хийх өдөр	Хэмжээ	Ачилт бүрийн төлбөр /НӨАТ багтсан/
1	Дахивар хог хаягдал	Сард 2 удаа	15,30 ны өдрүүдэд	3 тонн	50,000
2	Бусад хог хаягдал	Долоо хоногт 1 удаа	Баасан гариг бүр	4 тонн	150,000
3	Барилгын хог хаягдал	Дуудлагаар	Дуудлагаар	8 тонн	220,000

- 2.6 Хог хаягдал тээвэрлэлтийн төлбөрт хог хаягдлыг ачих, буулгах зэрэг хөлс бүгд багтсан болно.
- 2.7 Гүйцэтгэгч нь тухайн сард ачиж тээвэрлэсэн хог, хаягдлыг ачилтын давтамж, хогны төрөл, тэдгээрийн нэгж үнийн дүнгээр тооцож, сар бүрийн 20-ны дотор төлбөрийн нэхэмжлэхийг Захиалагчид хүргүүлнэ.
- 2.8 Талууд сар бүрийн 25-ны өдөр тооцоо нийлж акт үйлдэх бөгөөд Гүйцэтгэгч талын тухайн сард үйлдсэн тээврийн тооцоо, замын хуудсыг үндэслэнэ.
- 2.9 Захиалагч нь Гүйцэтгэгчийн нэхэмжлэх болон тооцоо нийлсэн актыг үндэслэн сар бүрийн 25-ны өдрийн дотор тээвэрлэлтийн төлбөрийг Гүйцэтгэгчийн **Голомт банкны 1905006672 тоот дансанд** төлнө. Гүйцэтгэгч нь НӨАТ-ын баримтыг тухай бүрт нь Захиалагчид шивж, шаардлагатай тохиолдолд цаасаар гаргаж өгнө.
- 2.10 Захиалагч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй хугацаа хэтрүүлсэн хоногт тутамд гэрээний нийт үнийн дүнгийн 0,5%-иар тооцон Гүйцэтгэгчид алданги төлнө.
- 2.11 Гүйцэтгэгч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй хог ачих хугацаа хэтрүүлсэн хоногт тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5%-иар тооцон Захиалагчид алданги төлнө.
- 2.12 Гүйцэтгэгч нь хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны хууль, дүрэм журмыг баримтлан ажиллах бөгөөд уг хууль, дүрэм журмыг хангаагүйн улмаас Захиалагчид болон гуравдагч этгээдэд хохирол учрах, хүний эрүүл мэнд, амь нас хохирсон тохиолдолд хохирлыг бүрэн хариуцна.
- 2.13 Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүйгээс Захиалагч болон гуравдагч этгээдэд хохирол учруулсан тохиолдолд Захиалагчаас учирсан хохирлоо нэхэмжлэн төлүүлэхээр зарцуулсан өмгөөлөгчийн хөлс, эрх бүхий холбогдох байгууллагын туслалцаа авахаар гаргасан /улсын тэмдэгтийн хураамж, нотариатын үйлчилгээний хураамж, шинжээчийн ажлын хөлс, унаа, харилцаа холбоо, банкны үйлчилгээ, томилолтын зардал болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал, үнэлгээний хураамж, тээвэрлэлт, хадгалалттай холбогдох г.м/ бүхий л нэмэлт зардлыг үл маргах журмаар барагдуулах үүргийг энэхүү гэрээгээр хүлээнэ.

Гурав. Гүйцэтгэгч талын эрх, үүрэг

- 3.1 Гүйцэтгэгч нь Захиалагчтай байгуулсан гэрээнд заасан хуваарийн дагуу Захиалагчийн хог хаягдлыг саадгүй ачиж тээвэрлэх үүрэгтэй.
- 3.2 Тээвэрлэлт саатсанаас хог хаягдал хуримтлагдсан бол өөрийн зардлаар нэмэгдэл хүч зохион байгуулан яаралтай ачуулах арга хэмжээ авна.
- 3.3 Гүйцэтгэгч нь хог хаягдлыг тээвэрлэх аюулгүй ажиллагааны шаардлага хангасан, битүүмжилсэн зориулалтын тээврийн хэрэгсэлтэй байх бөгөөд хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх үед түүнийг унах, асгарах, хийсэхээс сэргийлэх арга хэмжээ авна.
- 3.4 Гэрээний хугацаанд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг чанд сахин ажиллах үүрэгтэй бөгөөд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаатай холбоотой болон гэрээний дагуу үүрэг гүйцэтгэсэнтэй холбоотой үүсэх аливаа эрсдэл, хохирлыг дангаар хариуцна.
- 3.5 Ажлын цагийн горим, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны журам, замын хөдөлгөөний дүрэм журам, ачаа тээвэрлэлттэй холбоотой бусад дүрэм журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгох

.....
Анжир

Талуудын гарын үсэг

.....
О. Бямба

бөгөөд тээвэрлэж буй зүйл болон тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал, тээврийн хэрэгслийн шатахуун, ажиллах хүч, жолоочийг гүйцэтгэгч тал өөрөө хариуцна.

- 3.6 Гүйцэтгэгч нь энэхүү Захиалагчийн хог, хаягдлыг өөрийн зардал, тоног төхөөрөмж, хүн хүчийг ашиглан ачиж, тээвэрлэн, тогтоосон цэгт хаях болон хог хаягдлын тоо хэмжээг гаргах ажлыг хийж гүйцэтгэх бөгөөд энэхүү ажилтай холбоотой бүхий л эрсдэл зардлыг бүрэн хариуцна.
- 3.7 Гүйцэтгэгч нь хог хаягдал тээвэрлэх ажиллагаандаа ISO9001:2015, ISO14001:2015, OHSAS 18001:2007 стандартуудыг мөрдлөг болгон ажиллана.
- 3.8 Хог ялган ангилсны дараа ялгасан хогийг энгийн хог хаягдалтай холихгүй тусад нь тээвэрлэнэ.
- 3.9 Хог хаягдал ачих, тээвэрлэх, буулгах ажлыг стандарт технологийн дагуу зөв зохион байгуулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг ханган ажиллах асуудлыг зохион байгуулж үүнийг хангаагүйн улмаас учирсан хохирлыг хариуцна.
- 3.10 Гүйцэтгэгч нь хог хаягдлыг хугацаандаа ачиж тээвэрлээгүй, эсвэл ачих, тээвэрлэх, буулгах ажлыг зохих ёсоор гүйцэтгээгүйгээс Захиалагчид болон гуравдагч этгээдэд хохирол учирвал учирсан хохирлыг бүрэн хариуцна.
- 3.11 Нөгөө талаас гэрээгээр хүлээсэн үүргээ тогтоосон хугацаанд, шударгаар гүйцэтгэхийг шаардах эрхтэй.
- 3.12 Захиалагч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тогтоосон хугацаанд төлбөрөө барагдуулаагүй тохиолдолд хог хаягдлыг ачиж тээвэрлэхгүй байх эрхтэй.

Дөрөв. Захиалагч талын эрх, үүрэг


- 4.1 Хог агуулах савыг өөрийн хөрөнгөөр шийдвэрлэх бөгөөд хог ачихад саад учруулахгүй газар байрлуулна.
- 4.2 Хог хаягдал тээвэрлэлтийн хөлсийг Гэрээнд заасан хугацаанд төлөх үүрэгтэй.
- 4.3 Гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар гүйцэтгэх үүрэгтэй.
- 4.4 Гүйцэтгэгчээр гэрээнд заасан ажил үүргийг гүйцэтгүүлэх эрхтэй.
- 4.5 Хог хаягдлын тоо хэмжээний баталгаажуулалтыг хийхэд өөрийн төлөөлөгчөөр дамжуулан хяналт тавих эрхтэй.
- 4.6 Нөгөө талаас гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар гүйцэтгэхийг шаардах эрхтэй.
- 4.7 Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй тохиолдолд гэрээнд заагдсан хариуцлага хүлээлгэх эрхтэй.
- 4.8 Гүйцэтгэгч нь ажил үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд төлбөр төлөхгүй байх эрхтэй.
- 4.9 Гүйцэтгэгчид захиалга өгснөөс хойш гүйцэтгэгч нь хог хаягдлыг цаг хугацаанд нь ачаагүй, хуримтлал үүсгэвэл гуравдагч этгээдээр хог ачуулах эрхтэй бөгөөд үүнтэй холбоотой гарсан зардлыг гүйцэтгэгчээс гаргуулан авах эрхтэй.

Тав. Гэрээний үйлчлэх болон ажил гүйцэтгэх хугацаа, гэрээг өөрчлөх ба цуцлах журам


- 5.1 Энэхүү гэрээ нь 2022 оны 02 сарын 01 -ний өдрөөс эхлэн 1 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 5.2 Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлийг өөрчлөх буюу цуцалж болно.
- 5.3 Нэг талын санаачилгаар Гэрээг цуцлах тохиолдолд энэ тал нь нөгөө талдаа нэг сарын өмнө бичгээр мэдэгдэх үүрэгтэй.
- 5.4 Аль нэг талын үүргийн зөрчлөөс үүдэн нөгөө тал Гэрээнээс татгалзсан бол гэм буруутай тал нь нөгөө талд учирсан аливаа хохирлыг барагдуулна.
- 5.5 Гэрээг дараах тохиолдолд Захиалагч дангаар цуцална.
 - 5.5.1 Гүйцэтгэгч нь гэрээний дагуу гүйцэтгэх ажлаа хугацаанд нь зохих ёсоор гүйцэтгээгүй.
 - 5.5.2 Гүйцэтгэгч нь хариуцсан ажлаа удаа дараалан (2 ба түүнээс дээш) чанаргүй гүйцэтгэсэн.

Долоо. Бусад.

- 6.1 Гэрээг 2 хувь үйлдэн, гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно.
- 6.2 Талууд харилцан тохиролцож гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмэлт өөрчлөлт нь гэрээний нэгэн адил хүчин төгөлдөр үйлчилнэ. Нэмэлт өөрчлөлтийг бичгээр үйлдэх бөгөөд эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурж баталгаажуулна.

.....


Талуудын гарын үсэг

.....


- 6.3 Талууд Гэрээгээр хүлээсэн үүргээ гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас (дайн, нийтийг хамарсан үймээн самуун, мөн үүргийн гүйцэтгэлд нөлөөлөхүйц төрийн эрх бүхий байгууллагын хорио, цээр, халдварт өвчин, гал, ус, салхи, шуурганы нийтийг хамарсан аюулт үзэгдэл гэх мэт хамаарах бөгөөд Монгол Улсын цаг агаарын нөхцөл байдал хамаарахгүй) гүйцэтгэх боломжгүй болсон нь эрх бүхий байгууллагын шийдвэр, үндэслэл бүхий нотлох баримтаар тогтоогдсон бол тухайн хугацааны турш гүйцэтгэх үүргээс чөлөөлөгдөнө.
- 6.4 Гэрээтэй холбоотой маргаан гарвал талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.
- 6.5 Гэрээний 6.2-т зааснаар маргааныг шийдвэрлэж чадаагүй бол талууд Монгол Улсын шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Захиалагчийг төлөөлж:

“МСМ ГРУПП” ХХК-ийн МСМ ГРУПП ХХК
АБЭЦЦХХ У.Энхзул

Хаяг: Хан-уул дүүрэг, 3-хороо,
Чингисийн өргөн чөлөө, 62 байр
Утас: 88103072



Гүйцэтгэгчийг төлөөлж:

“Эко орчин” ХХК-ийн
Гүйцэтгэх захирал Б.Есөнтөмөр

Хаяг: Баянгол дүүрэг, 5-р хороо,
Ажилчны гудамж, 80/1 тоот
Утас: 70005012, 99053847



.....

Талуудын гарын үсэг

.....

ХАВСРАЛТ 3



АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ

2019 оны 6 сарын 25-ны өдөр

№ Сн-19/д1

Улаанбаатар хот

Нэг талаас **Цэцүүх трейд ХХК** /цаашид “Хүлээн авагч” гэх/ төлөөлж ерөнхий нягтлан бодогч албан тушаалтай Б.Даваажав,

Нөгөө талаас **МСМ Групп ХХК**-г /цаашид “Үүсгэгч” гэх/ төлөөлж ХАБЭАБО-ны Ахлах менежер албан тушаалтай М.Бек бид харилцан тохиролцож Монгол улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль Засгийн газрын 2018 оны 116-р тогтоолын 1, 2-р хавсралт болох “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх тайлагнах журам”, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаал болон Байгаль орчны аюулгүй байдалтай холбогдох хууль, журмыг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Гэрээний агуулга

- 1.1. Энэхүү гэрээгээр Аюултай хог хаягдал үүсгэгчээс аюултай хог хаягдлын дагалдах бичгийн дагуу түүнээс гарч байгаа аюултай хог хаягдлыг хүлээн авагч нь хүлээн авч хадгалах, дахин боловсруулах, устгалд оруулах, үүсгэгч нь хүлээн авагчид тохиролцсон үнийг төлөх болон талуудын эдлэх эрх, үүрэг хариуцлагын талаар зохицуулна.
- 1.2. Эл гэрээгээр шууд зохицуулагдаагүй бусад харилцааг Монгол улсын Иргэний хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулна.
- 1.3. Аюултай хог хаягдлын тоо хэмжээ, төрөл болон үнийн талаар гэрээний Хавсралт 1-т тусгах ба талууд гэрээний хугацаанд аюултай хог хаягдлыг шилжүүлэх бүртээ дагалдах бичгийг гэрээнд хавсаргах ба энэ нь гэрээний салшгүй хэсэг байна.

Хоёр. Аюултай хог хаягдал тавигдах шаардлага

- 2.1. Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж “Аюултай хог хаягдал” гэсэн тэмдэглэгээтэй байна.
- 2.2. Аюултай хог хаягдал савласан сав бүр нь ямар химийн бодис хадгалж байсан тухай нэр шошготой байна.
- 2.3. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг шилжүүлэх бүртээ үүссэн болон хуримтлагдсан хог хаягдлын хэмжээний талаарх бүртгэлийг хүлээн авагчид шилжүүлнэ.
- 2.4. Аюултай хог хаягдлыг шилжүүлэхдээ БОАЖЯ Сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаалын 1-р хавсралтад заасан маягтын дагуу дагалдах бичгийг бүрдүүлж өгнө.

- 2.5. Аюултай хог хаягдлын савыг бүрэн суллаж зохих журмын дагуу цэвэрлэсэн байна. Хоосон сав нь ЗГ-н 2018 оны 116-р тогтоолын 1-р хавсралтын 5.7-5.9-д заасан шаардлагыг хангасан байвал зохино.
- 2.6. Үүсгэгч Аюултай хог хаягдлыг “Аюултай хог хаягдал” тээвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий Аж ахуй нэгжийн тээврийн хэрэгслээр ачиж, тээвэрлүүлж хүлээн авагчид шилжүүлнэ.

Гурав. Аюултай хог хаягдлыг нийлүүлэх хугацаа, төлбөр төлөх нөхцөл

- 3.1. Үүсгэгч аюултай хог хаягдлыг улиралд 1 удаа хүлээн авах цэг дээр хүргэнэ.
- 3.2. Энэхүү гэрээний 1-р хавсралтад заасан Үүсгэгчээс гарах хаягдлын урьдчилсан төлөвлөгөөний дагуу аюултай хог хаягдалын хуримтлал үүссэн тохиолдолд үүссэн хаягдлын хэмжээнээс хамаарч 90-ээс 180 хоногт аюултай хог хаягдлыг хүлээн авагчид шилжүүлсэн байна.
- 3.3. Үүсгэгч нь гэрээний төлбөрийг Хавсралт 1-т заасан үнийн дагуу тооцож аюултай хог хаягдлыг хүлээн авагчид зохих журмын дагуу хүлээлгэн өгч, түүнийг хүлээн авагч хүлээн авсан тухай акт үйлдэн шилжүүлэн авснаар төлнө.
- 3.4. Аюултай хог хаягдлыг хүлээн авагч хүлээн авах үед үүсгэгчийн аюултай хог хаягдал гэрээний Хавсралт 1-т зааснаас тоо, хэмжээ болон дагалдах бичигт заасан мэдээлэл зөрсөнөөс үүдэж гэрээний үнэ өөрчлөгдөж болно. Энэ тохиолдолд хог хаягдлыг хүлээн авах үед тооцож гаргасан үнээр бодож үүсгэгч хүлээн авагчид төлбөрийг төлнө.
- 3.5. Төлбөрийг Цэцүүх трейд ХХК, Голомт банкны 1715109241 тоот дансанд нэхэмжлэхийг хүлээн авсанаас хойш ажлын 3 хоногийн дотор үүсгэгч хүлээн авагчид шилжүүлнэ.
- 3.6. Үүсгэгч нь хүлээн авагчийн тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр аюултай хог хаягдлыг тээвэрлүүлж, хүргэлтийн цэг дээр хүргүүлж болно. Хүлээн авагчийн тээврийн хэрэгслээр хог хаягдал ачиж, тээвэрлүүлэх тохиолдолд тусад нь хог хаягдал тээвэрлэх гэрээ байгуулан, гэрээний дагуу зохих төлбөрийг төлнө.

4. Дөрөв. Талуудын эрх, үүрэг

- 4.1. Үүсгэгчийн эрх, үүрэг:
 - 4.1.1. Үүсгэсэн аюултай хог хаягдлаа гэрээнд заасан хугацааны дотор зохих журмын дагуу хүлээн авахыг хүлээн авагчаас шаардах эрхтэй.
 - 4.1.2. Үүсгэгч нь гэрээний 3-р зүйлд заасан шаардлагыг хангасан аюултай хог хаягдлыг хүлээн авагчид хүлээлгэн өгнө.
 - 4.1.3. Аюултай хог хаягдлыг хүлээн авагчид ачих, хүргэх тээврийн зардлыг хариуцна.
 - 4.1.4. Үүсгэгч Аюултай хог хаягдлыг хүлээн авагчаар тээвэрлүүлэхээр бол тусад нь аюултай хог хаягдал тээвэрлэх гэрээ байгуулна.
 - 4.1.5. Гэрээгээр тохиролцсон төлбөрийг хүлээн авагчид хугацаанд нь төлнө.
 - 4.1.6. Шилжүүлэх аюултай хог хаягдлын талаарх мэдээллийг хүлээн авагчид үнэн зөв мэдээлнэ. Худал, буруу ташаа мэдээлсэнээс талуудад болон байгаль орчинд хохирол учирвал үүнээс үүсэх хохирлыг үүсгэгч тал хариуцна.
 - 4.1.7. Үүсгэсэн аюултай хог хаягдлаа хүлээн авагчид шилжүүлэхдээ 5 доошгүй хоногийн өмнө хүлээн авагчид энэ тухай мэдэгдэнэ.
- 4.2. Хүлээн авагчийн эрх, үүрэг
 - 4.2.1. Үүсгэгчээс Гэрээний 3-д заасан шаардлагыг хангасан аюултай хог хаягдлыг зохих журмын дагуу хүлээн авах

- 4.2.2. Үүсгэгчээс шилжүүлсэн аюултай хог хаягдал нь дагалдах бичигт үл зохицол үүссэн, тоо, хэмжээтэйгээ зөрж байвал уг хаягдлыг хэсэгчлэн болон бүхэлд нь хүлээн авахаас татгалзах эрхтэй.
- 4.2.3. Аюултай хог хаягдал хүлээн авсан төлбөр тооцоог үүсгэгчээс гэрээнд заасан хугацааны дотор төлөхийг шаардах эрхтэй.
- 4.2.4. Аюултай хог хаягдлыг хүлээж авсан актыг үүсгэгчид гаргаж өгнө.
- 4.2.5. Хүлээн авагч аюултай хог хаягдлыг хүлээн авсанаас хойшхи түүний хадгалалт, устгал, дахин боловсруулалтыг хариуцна.
- 4.2.6. Үүсгэгчээс Аюултай хог хаягдал шилжиж ирэх үед хариуцсан ажилтнаа бэлэн байлгаж, зохих журмын дагуу хаягдлыг хүлээн авна.

Тав. Аюултай хог хаягдлыг шилжүүлэх, шилжүүлэн авах

- 5.1. Үүсгэгч гэрээгээр тохиролцсон хугацаандаа аюултай хог хаягдлыг хүлээн авах цэг буюу УБ хот Налайх дүүрэг, 4-р хорооны нутаг дэвсгэрт орших “ЦЭЦҮҮХ ПЕ&ПП ДАХИН БОЛОВСРУУЛАХ ЭКО ҮЙЛДВЭР”-т хүргэнэ.
- 5.2. Үүсгэгч гэрээнд заасан шилжүүлэх хугацаанаасаа өмнө аюултай хог хаягдлыг шилжүүлэх эрхтэй ба ингэх тохиолдолд Хүлээн авагчид энэ тухай 5-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдсэн байна.
- 5.3. Үүсгэгч аюултай хог хаягдлаа “Аюултай хог хаягдал” тээвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжийн тусгай зориулалтын, зохих тэмдэг тэмдэглэгээтэй тээврийн хэрэгслээр ачиж, тээвэрлүүлэн Хүлээн авагчид хүргэж өгнө.
- 5.4. Талууд аюултай хог хаягдлыг хүлээлцэхдээ дагалдах бичиг болон гэрээнд заасан тоо, хэмжээтэй нийцэж байгаа эсэх, үл зохицол байгаа эсэхийг шалгах ба нийцэж байвал энэ тухай акт үйлдэж гарын үсэг зурж хүлээн авагч тал хүлээн авна.
- 5.5. Дээр дурдсанаар аюултай хог хаягдал дагалдах бичигтэй зөрсөн, үл зохицол илэрсэн тохиолдолд хүлээн авагч хэсэгчлэн болон бүхэлд нь хүлээн авахаас татгалзаж болно. Энэ тохиолдолд Аюултай хог хаягдлыг үүсгэгчид буцааж хүргэхтэй холбогдон гарах зардлыг үүсгэгч тал хариуцна.

Зургаа. Өмчлөх эрх шилжих

- 6.1. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг Хүлээн авагчид хүлээлгэн өгөх хүртэл хог хаягдлын өмчлөгч байна.
- 6.2. Үүсгэгч нь Хүлээн авагчид аюултай хог хаягдлыг шилжүүлсэнээр өмчлөх эрх Үүсгэгчээс хүлээн авагчид шилжинэ.
- 6.3. Үүсгэгч нь хог хаягдлыг хүлээн авагчид ачиж, тээвэрлэн хүлээн авах цэг дээр хүлээлгэн өгснөөр өмчлөх эрх хүлээн авагчид шилжсэн гэж үзнэ.
- 6.4. Аюултай хог хаягдлыг хүлээн авах цэг дээр хүлээн авагчид хүлээлгэн өгөх хүртэл түүний үр шим, эрсдэл үүсгэгчид байх ба хүлээн авагчид хүлээлгэн өгснөөр үр шим, эрсдэл хүлээн авагчид шилжинэ.

Долоо. Хариуцлага, маргаан шийдвэрлэх журам

- 7.1. Аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн эсхүл үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас нөгөө талдаа учирсан аливаа хохирлыг холбогдох нотлох баримтад үндэслэн бүрэн хариуцаж нөхөн төлнө.

- 7.2. Үүсгэгч энэ гэрээний 4-д заасны дагуу үнийг төлөх хугацааг хэтрүүлсэн бол Талууд харилцан тохиролцож уг хугацааг сунгаснаас бусад тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг хэтрүүлсэн хоног тутамд Хүлээн авагчид төлнө.
- 7.3. Хэрэв Хүлээн авагч нь Үүсгэгчээс ирүүлсэн хог хаягдлыг энэ гэрээний 4.1-т заасан хугацааны дотор зохих журмын дагуу хүлээн аваагүй, хугацааг хожимдуулсан бол Талууд харилцан тохиролцож уг хугацааг сунгаснаас бусад тохиолдолд гэрээгээр тохиролцсон үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг хэтрүүлсэн хоног тутамд Үүсгэгчид төлнө.
- 7.4. Алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 10%-аас хэтрэхгүй байна.
- 7.5. Талууд гэрээнээс татгалзах болон цуцлах үндэслэлийг иргэний хуулиар зохицуулна.
- 7.6. Үүсгэгч тал аюултай хог хаягдлыг хүлээн авагчид шилжүүлэхдээ дагалдах бичиг болон гэрээний хавсралт 1-д заасан тоо хэмжээ, химийн бодисын нэр хаягийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй бөгөөд буруу, зөрүүтэй худал мэдээлсэнээс болж гэрээний үнийн дүн өөрчлөгдөх, эсвэл үүнээс үүдэж хохирол учирвал хүлээн авагч хариуцахгүй болно.
- 7.7. Энэ гэрээтэй холбогдон Талуудын хооронд үүссэн аливаа санал зөрөлдөөн, маргаантай асуудлыг Талууд эв зүйгээр хэлэлцэн шийдвэрлэхийг чармайх бөгөөд ийнхүү шийдвэрлэж чадаагүй бол маргааныг Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

Найм. Давагдашгүй хүчин зүйл

- 8.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал гэдэгт үерт автах, гал түймэрт нэрвэгдэх, дэлбэрэлтэд өртөх, газар хөдлөх, зуд болох, тахал болон бусад байгалийн хүчин зүйлс мөн цэрэг дайны үйл ажиллагаа, төрийн эрх барих байгууллагын шийдвэр буюу экспорт, импортын хориг, ажил хаялт, үйлдвэрлэгчийн бүх төрлийн сул зогсолт зэрэг худалдагчийн үйл ажиллагаанаас хамаарах үндэслэлээр энэхүү гэрээг зохих ёсоор биелүүлэх боломжгүй байдлыг бий болгохыг ойлгоно.
- 8.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээ биелэгдэх боломжгүй тохиолдолд талууд бие биедээ нэн даруй мэдэгдэх ба гэрээний хугацаа дээрх нөхцөл байдал арилах хүртэл хугацаагаар сунгагдах буюу тодорхой хугацаа зааж сунгаж болно.
- 8.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас бараа материал устсан, дутсан тохиолдолд шилжүүлэн хүлээлгэн өгөх хүртэлх эрсдэлийг үүсгэгч, шилжүүлэн хүлээн авснаас хойшхи эрсдэлийг хүлээн авагч хариуцна.
- 8.4. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлыг зохиомлоор буюу болгоомжгүйгээр бий болгосноос бусад тохиолдолд форс мажорын нөхцлөөс шалтгаалан учирсан хохирлыг хариуцах үүргээс талууд чөлөөлөгдөнө.

Ес. Бусад зүйл

- 9.1. Энэхүү гэрээний хэрэгжилтийн явцад гэрээнд аливаа нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд бичгээр үйлдэж эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

- 9.2. Гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг зөвхөн бичгээр оруулах ба талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 9.3. Энэхүү гэрээг Монгол хэл дээр хоёр хувь үйлдэж, Үүсгэгч тал 1 хувь, Хүлээн авагч тал 1 хувийг тус тус хадгалсан нь хуулийн ижил хүчинтэй.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Үүсгэгч талыг төлөөлж:
МСМ Групп ХХК-ийн
ХАБЭАБО-ны Ахлах менежер
М.Бек



Утас: 77181111

Хаяг: Хан-Уул дүүрэг, 3-р хороо,
Чингисийн өргөн чөлөө – 62,
Үйлдвэрийн бүс – 17070, МСМ Групп
ХХК өөрийн байр

Хүлээн авагч талыг төлөөлж:

Цэцүүх Трейд ХХК-ийн



Утас: 70189778, 99057704

Хаяг: Баянгол дүүрэг, 5-р хороо,
Энхтайвны өргөн чөлөө – 64/2, Цэцүүх
Трейд ХХК-ийн оффис, үйлчилгээний
байр

ХАВСРАЛТ 4

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
